

Аудит хийх үндэслэл: Монгол улсын Их хурлын Төсвийн байнгын хорооны 2014 оны 20 дугаар тогтоол, Үндэсний аудитын газрын 2015 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийв.

Аудитын ерөнхий дүгнэлт: Төв аймгийн ОНХС-д 2014 онд ОНХНС-аас өгөх санхүүжилтийг 2727.4 сая төгрөгөөр дутуу санхүүжүүлснээс төлөвлөсөн зарим төсөл арга хэмжээг хэрэгжүүлээгүй байна.

ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ЗАРЦУУЛАЛТЫН БАЙДАЛ



Зуунмод
2015 он

АГУУЛГА

<u>Аудитын тайланг бэлтгэсэн:</u>	Товчилсон үгийн тайлбар 3
ҮАГ-ын харьяа Төв аймгийн Аудитын газар	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт
Дарга, тэргүүлэх аудитор Л.Жаргалсайхан	БҮЛЭГ 1. Орон нутгийн хөгжлийн сангийн орлогын хууль, журамд заасны дагуу төлөвлөсөн боловч санхүүжилт дутуу хийгджээ. 5
Аудитын менежер О.Амаржаргал	1.1 Орон нутгийн хөгжлийн сангаас олгох шилжүүлгийг журмын дагуу тооцож төлөвлөсөн байна. 5
Аудитор Д.Пүрэвсүрэн Шинжээч Ч.Загдсүрэн	1.2 Улсын төсөвт тодотгол хийгдсэнтэй холбоотойгоор аймгийн 2014 оны төсөвт тодотгол хийж ОНХС-н орлогыг 689.3 сая төгрөгөөр бууруулсан байна. 11
2014 оны 10 дугаар сарын 20	1.3 Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгосон шилжүүлэг батлагдсан хэмжээгээр санхүүжигдээгүйгээс зарим төсөл арга хэмжээ хэрэгжээгүй байна. 13
Уг тайланг АГ-ын Веб сайтаас үзнэ үү. www.tuv-audit.mn	1.4 Орон нутгийн хөгжлийн сангийн орлогыг хууль, журамд заасны дагуу тооцож хуваарилсан байна. 15
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70273463 дугаарын утас, 70272582 дугаарын факсаар харилцана уу.	1.5 Орон нутгийн хөгжлийн сангийн орлогыг хууль, журамд заасны дагуу нэр төрөл тус бүрээр бүрдүүлсэн байна. 15
ХАЯГ:	БҮЛЭГ 2. Орон нутгийн хөгжлийн сангаар хийгдэж буй хөрөнгө оруулалтын ажлуудын зураг, төсөв нь санхүүжилтийн эх үүсвэр батлагдсны дараа буюу ИТХ-ын тогтоол гарсны дараа, хийгдэж байна. 17
Төв аймгийн Төрийн байгууллагын ордон	2.1 Аймгийн орон нутгийн хөгжлийн сангаар хийгдэж байгаа хөрөнгө оруулалтын ажил нь аймгийн Засаг даргын 2013-2016 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, 2014 онд аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлтэй уялдаж, сумд нь иргэдээс авсан саналын дагуу жагсаалт батлуулж, хэрэгжүүлж байна. 19
	2.2 Сумдад иргэдийн саналын дагуу эрэмблэгдэж, хийгдэж байгаа ажлууд нь зураг, төсөвгүй байна. 21
	2.3 Төв аймгийн Сумын ИТХ, багийн ИНХ-аар дэмжигдээгүй 184.2 сая төгрөгийн хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээ хэрэгжсэн байна. 22
	2.4 ОНХС-д төвлөрч байгаа хандивын орлогыг тухайн хандив өгч байгаа иргэн, аж ахуйн нэгж нь тодорхой зорилгоор өгч байгаа тул тухайн төсөл, арга хэмжээнд зарцуулагдаж, ОНХС-ийн журмын дагуу зарцуулагдахгүй байна. 24
	2.5 Сум, орон нутагт үнэлгээний хороонд ажиллаж байгаа АЗ гэрчилгээтэй иргэдийн мэдлэг дутмагаас худалдан 30

авах ажиллагааны хууль зөрчигдөж байна.

БҮЛЭГ 3. Сум, орон нутагт орон нутгийн хөгжлийн сангаар хийгдэж буй хөрөнгө оруулалтын ажилд захиалагчийн хяналт, явцын хяналт байхгүй байна.

3.1 Сум бүр ил тод байдлын самбар ажиллуулж, ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх ажлын төлөвлөгөө, гүйцэтгэлийг байршуулжээ.

3.2 ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэж буй ажлуудад тавих хяналт байхгүй байна.

3.3 Захиалагчийн хяналт байхгүйгээс гүйцэтгэгчтэй тооцсон хариуцлага байхгүй байна.

3.4 Өмнөх оны аудитаар өгсөн акт, албан шаардлага бүрэн хэрэгжсэн байна.

3.5 Сумд нь ил тод байдлын самбар ажиллуулж, ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх ажлын төлөвлөгөө, гүйцэтгэлээ байршуулсан байна.

Дүгнэлт
Зөвлөмж
 Холбогдох байгууллагаас ирүүлсэн санал
 Холбогдох байгууллагын саналын дагуу хэрэгжүүлсэн арга хэмжээ

Товчилсон үгийн тайлбар

МУ	Монгол Улс
УИХ	Улсын Их хурал
ЗГ	Засгийн газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
АМНАТ	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр
ААНБ	Аж ахуйн нэгж, байгууллага
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХК	Хувьцаат компани
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
ХАА	Худалдан авах ажиллагаа
БХБА	Барилга хот байгуулалтын алба
ХБХ	Хөгжлийн бодлогын хэлтэс
ГХБХБГ	Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар
ЭХЯ	Эрчим хүчний яам
ТББ	Тендерийн бичиг баримт
ТБОНӨХБАҮХАТ	Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын зорилт:

ОНХС-ийн 2014 оны хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалт, хэрэгжилтийн байдал, хууль, тогтоомжинд нийцсэн эсэхэд аудит хийж, дүгнэлт, санал, зөвлөмж боловсруулан дүнг УИХ, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэнэ. Үүнд:

- ОНХС-ийн орлогыг хууль, журамд заасан нэр төрлөөр нь бодитой төлөвлөж, бүрдүүлсэн эсэх
 - ОНХС-ийн хөрөнгийг хууль, тогтоомжид заасан журмын дагуу зарцуулсан эсэх
 - ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулсан эсэх
- Аудитын явцад “Шилэн дансны тухай” хуулийн хэрэгжилтийн байдалд дүгнэлт хийж, тайлагнана.

Аудитын хамрах хүрээ:

Аудитыг батлагдсан хуваарийн дагуу ОНХС-д 2014 онд улсын төсвөөс хуваарилж олгосон шилжүүлэг болон бусад эх үүсвэрээр бүрдүүлсэн хөрөнгийг хэрхэн зарцуулсан талаар тэдний гүйцэтгэсэн ажлын тайлан болон бусад холбогдох материалд тулгуурлан гүйцэтгэнэ.

Үндсэн мэдээлэл:

Монгол улсад 2013 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн мөрдөгдөж буй “Төсвийн тухай” шинэ хуулиар аймаг, нийслэл, сум, дүүрэгт “Орон нутгийн хөгжлийн сан” байгуулсан нь орон нутгийн төсвийн эрх мэдлийг нэмэгдүүлж, орон нутгийн удирдлагын идэвхи санаачлага, хариуцлагыг сайжруулсны зэрэгцээ төсвийн төлөвлөлт, зарцуулалтад иргэдийн оролцоог буй болгож, орон нутгийн хөгжлийг дэмжих, тулгамдсан асуудлыг иргэдийнхээ санал, санаачлагад тулгуурлан шийдвэрлэх ихээхэн үр дүнтэй ажил болжээ.

2014 оны “Төсвийн тухай хууль”-аар “Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан”-д дотоодын НӨАТ-аар 174.8 тэрбум, АМНАТ-өөр 38.2 тэрбум, аймаг, нийслэлээс төвлөрүүлэх орлогоор 71.7 тэрбум, нийт 284.4 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлж, аймаг, нийслэлд шилжүүлэхээр батлагдсныг төсвийн тодотголоор 265.8 тэрбум төгрөг болгож, гүйцэтгэлээр ОНХС-аас аймаг, нийслэлийн ОНХС-д 195.4 тэрбум төгрөгийн орлогын шилжүүлэг хийгдсэн байна.

Төв аймгийн хувьд аймгийн ИТХ-ын 2013 оны 12-р сарын 03-ний өдрийн 4 дүгээр хуралдааны 03 тоот тогтоолоор орон нутгийн хөгжлийн сангийн орлого буюу “Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан”-гаас олгох шилжүүлгийг 10307.4 сая төгрөгөөр баталжээ. 2014 онд ОНХСангийн санхүүжилт төлөвлөсөн хэмжээнээс дутуу ирсэн ба 2015 оны 3-р сарын 27-ны өдрийн 10 дугаар хуралдааны 07 тоот тогтоолоор тодотгол хийж ОНХСангаас олгох шилжүүлгийг 9618.2 сая төгрөг болгосон байна. ОНХСангаас 6890.8 сая төгрөгийн санхүүжилт авч, 4520.3 сая төгрөгийг сумдад, 2370.5 сая төгрөгийг аймгийн орон нутаг хөгжүүлэх санд хуваарилсан байна. ОНХСангаас хуваарилсан орлогын шилжүүлгийн гүйцэтгэл 72 хувьтай байна.

Аймгийн орон нутгийн хөгжлийн сан нь 2014 онд 1532.9 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй, 2014 онд улсын төвлөрсөн төсвөөс ОНХСангийн орлогын шилжүүлгээр 9618.2 сая төгрөг авах төлөвлөгөөтэйгөөс 6890.8 сая төгрөгийн санхүүжилт авчээ. Үүнээс 4520.3 сая төгрөгийг сумдын орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтэнд, 2370.5 сая төгрөгийг аймгийн орон нутгийн хөгжлийн санд олгож, 1059.7 сая төгрөгийн бусад орлого төвлөрч, нийт орлого 7950.5 сая төгрөг, сангийн хөрөнгийн нийт эх үүсвэр 9483.4 сая төгрөгнөөс 8547.7 сая төгрөг зарцуулагдаж, нийт 935.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна.

Засгийн газрын 2012 оны 30 дугаар тогтоолоор орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон орон нутгийн хөгжлийн сангаас олгох шилжүүлэг тооцох аргачлалыг батлан мөрдөж байна.

Эрсдлийн үнэлгээ:

Аудитын төлөвлөлтийн явцад цуглуулж судалсан баримт, материал, урьдчилсан дүн шинжилгээнд үндэслэн, хийх аудитын ерөнхий эрсдлийг “Дунд” гэж үнэллээ.

Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэхдээ Төрийн хяналт, шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын арга зүйг баримтлан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга авах, судалгаа гаргуулах, дүн шинжилгээ хийх аудитын горимын дагуу нотлох зүйл цуглуулж, дүн, дүгнэлт, зөвлөмж боловсруулна.

Аудитад ашиглах шалгуур үзүүлэлтүүд:

Аудитад дараахь хууль, эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглана.

- Төрийн аудитын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Нэгдсэн төсвийн тухай хууль
- УИХ, ЗГ-ын холбогдох тогтоол, шийдвэрүүд, хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан гаргасан дүрэм, журам

Аудит хийх бүрэлдэхүүн, хугацаа:

Аудитыг аймгийн аудитын газрын Аудитын менежер О.Амаржаргал удирдан, аудитор Д.Пүрэвсүрэн, шинжээч Ч.Загдсүрэн нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу 2015 оны 2 дугаар сарын 1-нээс 5 дугаар сарын 15-ны өдөр хүртэл хийж гүйцэтгэв.

ОНХС-ийн орлогыг хууль журамд заасан нэр, төрлөөр нь бодитой төлөвлөж, бүрдүүлж чадсан уу?

Бүлэг 1

Орон нутгийн хөгжлийн сангийн орлогын хууль, журамд заасны дагуу төлөвлөсөн боловч санхүүжилт дутуу хийгджээ.

1.1 Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох шилжүүлгийг хэрхэн төлөвлөсөн бэ?

Орон нутгийн хөгжлийн сангаас олгох шилжүүлгийг журмын дагуу тооцож төлөвлөсөн байна.

Аймгийн ИТХ-ын 2013 оны 12-р сарын 03-ний өдрийн 4 дүгээр хуралдааны 03 тоот тогтоолоор аймгийн 2014 оны төсвийг батласан байна. Уг тогтоолоор орон нутгийн хөгжлийн сангийн орлого буюу “Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан”-гаас олгох шилжүүлгийг 10307.4 сая төгрөгөөр баталсан байна. Үүнээс сумдын орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийг 6184.5 сая төгрөг, аймгийн хөгжлийн санд 4122.9 сая төгрөг батлагдсан. 2014 онд ОНХСангийн санхүүжилт төлөвлөсөн хэмжээнээс дутуу ирсэн ба улсын төсөвт тодотгол хийгдсэнтэй холбоотойгоор аймгийн ИТХ-ын 2015 оны 3-р сарын 27-ны өдрийн 10 дугаар хуралдааны 07 тоот тогтоолоор тодотгол хийж, ОНХСангаас олгох шилжүүлгийг 9618.2 сая төгрөг болгосон бөгөөд сумдад олгох орлогын шилжүүлгийг хэвээр буюу 6184.5 сая төгрөгөөр, аймгийн орлогын шилжүүлгийг 689.3 сая төгрөгөөр бууруулж баталсан байна.

	Анхны төсөв	Тодотгосон төсөв
Орлого	10307.5	9618.2
Орон нутгийн хөгжлийн сангийн орлого	10307.5	9618.2
Зарлага	10307.5	9618.2
Сумын орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлэг	6184.5	6184.5
Аймгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт	4123.0	3433.7

Орон нутгийн хөгжлийн сангаас орон нутгийн төсөвт олгох шилжүүлгийг Засгийн газрын 2012 оны 09 сарын 15-ны өдрийн “Орон нутгийн төсвийн аргачлал батлах тухай” 30 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан аргачлалын дагуу тооцож олгосон байна.

1.2 Орон нутгийн хөгжлийн сангийн орлогыг хууль, журамд заасан нэр төрөл тус бүрээр бодитой төлөвлөж чадсан уу?

Батлагдсан хэмжээнд санхүүжилт хийгдээгүйгээс 2014 оны төсөвт тодотгол хийж 689.3 сая төгрөгөөр бууруулсан байна.

2015 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн аймгийн ИТХ-ын 10 дугаар хуралдааны 7 тоот тогтоолоор аймгийн 2014 оны төсөвт тодотгол хийхдээ хандив, тусламжийн орлогыг төлөвлөөгүй байна.

“Төсвийн тухай хууль”-ийн 59.1-д “Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан нь дараахь эх үүсвэрээс бүрдэнэ: 1. импортоос бусад бараа, ажил, үйлчилгээний нэмэгдсэн өртгийн албан татварын орлогын 25 хувь; 2. Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн

орлогын 5 хувь зэрэг орлогоос бүрдэнэ гэж заасан. 2014 онд аймгийн орон нутгийн хөгжлийн санд ОНХНС-аас 10307.5 сая төгрөгийн орлогын шилжүүлэг авахаар төлөвлөсөн боловч тодотголоор 9618.2 сая төгрөг болгож, 689.3 сая төгрөгөөр бууруулсан байна. Мөн хандивын орлогыг төлөвлөөгүй байна.

Орлого	10123.2	7950.5
Орон нутгийн хөгжлийн сангийн орлого	9618.2	6890.8
Газрын дуудлага худалдааны анхны үнэ	505.0	332.3
Хандив		650.3
Бусад орлого		77.1

Орон нутгийн хөгжлийн санд олгох шилжүүлгийг журмын дагуу тооцсон боловч батлагдсан хэмжээнд санхүүжилт хийгдээгүй, 2014 оны төсөвт тодотгол хийж 689.3 сая төгрөгөөр бууруулсан байна.

1.3 Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох шилжүүлгийг бүрэн авч төсөл арга хэмжээнд шингээж чадсан эсэх?

Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгосон шилжүүлэг батлагдсан хэмжээгээр санхүүжигдээгүйгээс зарим төсөл арга хэмжээ хэрэгжээгүй байна.

ОНХНСангаас олгох шилжүүлэг батлагдсан төлөвлөгөөр 9618.2 сая төгрөг байгаа боловч гүйцэтгэлээр 6890.8 сая төгрөгийн санхүүжилт авч, 4520.3 сая төгрөгийг сумдад, 2370.5 сая төгрөгийг аймгийн орон нутаг хөгжүүлэх санд хуваарилсан нь байна. ОНХНСангаас хуваарилсан орлогын шилжүүлгийн гүйцэтгэл нь батлагдсан төлөвлөгөөтэй харьцуулахад 72 хувьтай буюу 2727.4 сая төгрөгөөр дутуу санхүүжигдсэн байна. 2014 оны батлагдсан төлөвлөгөөгөөр аймгийн хэмжээгээр 398 төсөл арга хэмжээнд 9618.2 сая төгрөг зарцуулахаар төлөвлөсөн боловч батлагдсан төсөл, арга хэмжээнээс 340 төсөл арга хэмжээ хэрэгжиж, 7581.4 сая төгрөг зарцуулагдсан байна. ОНХНСангаас олгох санхүүжилт дутуу ирсэнээс 2014 онд аймгийн хэмжээнд 58 төсөл, арга хэмжээ хэрэгжээгүй байна.

1.4 ОНХНС-аас олгосон шилжүүлгийг сум, дүүргийн ОНХСанд хуваарилахдаа холбогдох журмыг баримталсан эсэх?

Орон нутгийн хөгжлийн сангийн орлогыг хууль, журамд заасны дагуу тооцож хуваарилсан байна.

Аймгийн орон нутгийн хөгжлийн сангаас сумдын хөгжлийн орон нутгийн хөгжлийн санд орлогын шилжүүлгийг тооцохдоо дараах үзүүлэлтүүдийг харгалзан тооцож хуваарилалтыг хийжээ. Үүнд:

- А. Сумын хүн амын тооны индекс
- Б. Нутаг дэвсгэрийн хэмжээ индекс
- В. Алслалтын хэмжээ индекс
- Г. Татварын идэвх санаачилгын индекс:
 - Орон нутгийн орлогын төлөвлөгөөний биелэлт
 - Татвар төлөгчийн татварт хамрагдсан байдал
 - Татварын өр барагдуулалтын үзүүлэлт

Сумын нэр	Хүн амын тооноос хамааруулан олгох дүн	Хүн амын нягтрал, алслат, нутаг дэвсгэрийн хэмжээнээс хамааруулан олгох дүн	Орон нутгийн татварын идэвх санаачлагаас хамааруулан олгох дүн	Итгэлцүүрт үндэслэн хуваарилсан дүн
Алтанбулаг	70.9	101.7	87.1	259.6
Аргалант	36.9	48.6	69.6	155.1
Архуст	29.2	41.7	79.6	150.4
Батсүмбэр	159.7	51.5	80.8	292.0
Баян	47.7	71.3	84.6	203.6
Баяндэлгэр	31.7	72.9	70.8	175.4
Баянжаргалан	36.7	79.8	78.2	194.8
Баян-Өнжүүл	47.9	117.8	76.2	241.9
Баянхангай	33.1	51.3	76.7	230.7
Баянцагаан	40.4	160.6	80.1	281.2
Баянцогт	42.7	55.1	88.4	186.2
Баянчандмань	85.0	28.6	74.6	188.2
Борнуур	113.8	40.8	76.2	230.7
Бүрэн	71.4	94.8	74.1	240.3
Дэлгэрхаан	31.6	97.6	83.1	212.3
Жаргалант	148.7	53.4	72.9	275.0
Заамар	121.1	77.1	73.6	271.8
Лүн	61.0	74.9	80.6	216.4
Мөнгөнморьт	48.7	165.9	77.7	292.3
Өндөрширээт	43.5	96.8	83.6	223.9
Сэргэлэн	43.5	83.2	70.1	196.8
Сүмбэр	42.9	43.1	60.2	146.2
Угтаал	60.9	61.8	65.4	188.1
Цээл	59.2	68.1	54.5	181.8
Эрдэнэ	88.7	134.9	80.0	303.6
Эрдэнэсант	104.2	88.1	86.0	278.3
Зуунмод	360.2	0.2	76.9	437.3
НИЙТ	2061.5	2061.5	2061.5	6184.5

Сумдад олгох орлогын шилжүүлгийг нийт орлогын шилжүүлгийн 60 хувиар тооцсон ба орон нутгийн хөгжлийн индексийг тооцолгүй, үлдэх 3-н итгэлцүүрт тэнцүү байдлаар хувааж тооцсон байна. Үүнд: хүн амын тооноос хамаарах 33.3 хувь, хүн амын нягтрал, алслалт нутаг дэвсгэрийн хэмжээнээс хамаарах 33.3 хувь, татварын идэвх санаачлагаас хамаарах 33.3 хувь тус тус байхаар тооцсон байна.

1.5 Орон нутгийн хөгжлийн сангийн орлогыг хууль журамд заасан нэр төрөл тус бүрээр бүрдүүлж чадсан уу?

Орон нутгийн хөгжлийн сангийн орлогыг хууль, журамд заасны дагуу нэр төрөл тус бүрээр бүрдүүлсэн байна.

ОНХС-аас олгох орлогын шилжүүлгийн 9618.2 сая төгрөгийн санхүүжилтээс гадна 2013 оны аймгийн ИТХ-ын 6 дугаар хуралдааны /12 сарын 03/ 1 тоот тогтоолын 11-д “Газрын тухай хуулийн зарим заалтын хэрэгжилтийг хангах тухай аймгийн ИТХ-ын Тэргүүлэгдчийн 2012 оны 77 дугаар тогтоолын дагуу төсөвт төвлөрөх орлогын 50 хувийг аймгийн “Орон нутгийн хөгжлийн сан”-д, 50 хувийг тухайн сумын “Орон нутгийн хөгжлийн сан” болон төсөвт хуваарилан олгохоор тогтоосугай” гэсний дагуу 505.0 сая төгрөг төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр аймгийн төсөвт газрын дуудлага худалдааны анхны үнэ 496.8 сая төгрөг төвлөрсний 332.3 сая төгрөгийг аймгийн орон нутгийн хөгжлийн санд хуваарилж, 164.5 сая төгрөгийг дутуу төвлөрүүлсэн байна. Мөн төлөвлөгөөнд тусгагдаагүй хандивын орлого 650.3 сая төгрөг, бусад орлого 77.1 сая төгрөг төвлөрсөн байна.

	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
Эхний үлдэгдэл		1532.9
Орлого	10123.2	7950.5
Орон нутгийн хөгжлийн сангийн орлого	9618.2	6890.8
Газрын дуудлага худалдааны анхны үнэ	505.0	332.3
Хандив		650.3
Бусад орлого		77.1
ОНХС-ийн нийт эх үүсвэр		9483.4
Зарлага	9621.1	8547.7
Сумын ОНХСанд хуваарилсан орлогын шилжүүлэг	6187.4	5756.5
Аймгийн хөгжлийн санд хуваарилсан орлогын шилжүүлэг	3433.7	2791.2
Эцсийн үлдэгдэл		935.7

Аймгийн ОНХС-д нийт 77.1 сая төгрөгийн бусад орлого төвлөрсөн нь 13 сумын ОНХС-д орсон байна. Үүнээс 36.6 сая төгрөг нь Баян өнжүүл сумын ТАХ-ын орон сууцны урьдчилгаа төлбөр, Архуст сум зураг төсвийн 7.8 сая төгрөг, тендерийн бичиг баримтын үнэ 1.7 сая төгрөг, Жаргалант сум ковшийн орлого 6.6 сая төгрөг гэх мэт орлогуудыг төвлөрүүлсэн байна.

ОНХС-ийн хөрөнгийг хууль, тогтоомжид заасан журмын дагуу зарцуулсан уу?

Бүлэг 2

Орон нутгийн хөгжлийн сангаар хийгдэж буй хөрөнгө оруулалтын ажлуудын зураг, төсөв нь санхүүжилтийн эх үүсвэр батлагдсны дараа буюу ИТХ-ын тогтоол гарсны дараа, хийгдэж байна.

2.1 ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдсан эсэх, иргэдийн саналыг эрэмбэлсэн жагсаалтыг мөрдөж ажилласан уу?

Аймгийн орон нутгийн хөгжлийн сангаар хийгдэж байгаа хөрөнгө оруулалтын ажил нь аймгийн Засаг даргын 2013-2016 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, 2014 онд аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлтэй уялдаж, сумд нь иргэдээс авсан саналын дагуу жагсаалт батлуулж, хэрэгжүүлж байна.

ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдсан эсэх, иргэдийн саналыг эрэмбэлсэн жагсаалтыг мөрдөж ажилласан байдлыг нийцлийн аудитаар шалгалаа. Сумдууд 2014 оны ОНХС-аар хийгдэх ажилд иргэдийнхээ саналыг авч, багийн ИНХ-аар хэлэлцүүлэн тогтоол гаргасныг, сумын ЗДТГ-аас гарсан ажлын хэсэг эрэмбэлэн, дараа онд ОНХСангийн хөрөнгөөр хийгдэх хөрөнгө оруулалтын ажлын жагсаалтаа ИТХ-аараа батлуулж, ажилласан байна. Аймгийн 27 сумын хэмжээнд иргэдийн саналыг эрэмбэлсэн жагсаалтаар сум орон нутгийн тэргүүлэх чиглэл болон нийгэм эдийн засгийн тулгамдсан ач холбогдолтой гэж үзсэн 6168.2 сая төгрөгийн 366 төсөл, хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 5370.0 сая төгрөгийн 316 төсөл, хөтөлбөр, арга хэмжээ хэрэгжиж, 798.2 сая төгрөгийн 50 төсөл, хөтөлбөр, арга хэмжээг төсөв санхүүгийн хүрэлцээгүй байдлаас шалтгаалан төсвийн тодотголоор хасагдаж, хийгдээгүй байна.

Аймгийн хөгжлийн сангаар хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээг аймгийн Засаг даргын 2013-2016 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, 2014 онд аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлтэй уялдуулан, 2014 онд аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 4122.9 сая төгрөгийн 37 ажлын жагсаалтыг аймгийн ИТХ-аар оруулан батлуулсан байна. Мөн 2015 оны 3 сарын 27-ны өдрийн 10 дугаар хуралдааны 07 тоот тогтоолоор 2014 оны аймгийн төсөвт тодотгол хийж, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх 3433.7 сая төгрөгийн 33 төсөл, арга хэмжээг батласан байна.

Уг тодотголд аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 905.1 сая төгрөгийн шинээр эхлэх 3 хөрөнгө оруулалт, 2013-2014 онд он дамжин хийгдсэн 112.2 сая төгрөгийн 2 ажил, 468.0 сая төгрөгийн 6 их засвар, 378.5 сая төгрөгийн 7 зураг, төсөв, ТЭЗҮ, нийгмийн даатгалын шимтгэлийн өрөнд хураагдсан барилгыг төр, захиргааны 2 дугаар байр болгон ашиглах зорилгоор төлөх барилгын үнэ 342.7 сая төгрөг, 1227.2 сая төгрөгийн 14 төсөл, хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан байна.

Аймгийн хэмжээнд нийт 6301.9 сая төгрөгийн 399 хөрөнгө оруулалтыг орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийхээр батлаж, хэрэгжүүлжээ.

ОНХСангийн хөрөнгөөр 2014 онд хийгдэх төсөл арга хэмжээг нийт сумд иргэдийн саналыг үндэслэн ИТХ-аараа батлан хэрэгжүүлсэн боловч тухайн сумын эдийн засаг нийгмийн тулгамдсан, тэргүүлэх чиглэлийн асуудлаа бүрэн дүүрэн тодорхойлон төлөвлөж хэрэгжүүлэх тал дээр дутагдалтай байна.

Сумдын 2014 онд хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээг тухайн сумын төрийн үйлчилгээ, нийгэм эдийн засгийн ач холбогдлоор нь ангилж үзвэл ихэнх сумд гудамжны гэрэлтүүлэг,

цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламж, усан оргилуур, хүүхдийн тоглоомын талбай, ахуй үйлчилгээний байр, худаг гаргах, мал угаалгын ванн, нийтийн эзэмшлийн зам талбай, гүүр, үерийн далан барьж байгуулахад зарцуулсан байхад зарим сумд жишээлбэл Баян, Батсүмэр, Бүрэн, Аргалант сумд 25.0-50.0 сая төгрөгийн үнэтэй ёслол хүндэтгэлийн өргөө гэр худалдан авчээ. Зарим сумд тэмдэглэлт ойг тохиолдуулан нутгийн иргэдийн хандиваар хийж болохуйц наадмын талбай, морь барианы газар, сумын өндөрлөг, морины хөшөө барих зэргийг тус сангийн хөрөнгөөр хийж байгаа нь төсвийн хөрөнгийг үр ашиг, үр өгөөж муутай зүйлд зарцуулсан байна гэж дүгнэж болохоор байна.

Сумын төвийн цэцэрлэгт хүрээлэн ногоон байгууламж барих ажилд 2012 онд улс орон нутгийн төсвийн хөрөнгөөр ихэнх сумдад тус бүрд нь 20.0 сая төгрөг хуваарилан зарцуулж байсны үр дүн төдийлөн гараагүй чанаргүй байгууламж барих, эзэмшилт ашиглалт хангалтгүй байснаас жил бүр энэхүү байгууламжид төсөв мөнгө хуваарилж байгаа нь оновчгүй төлөвлөж байгааг харуулж байна.

Аудитын явцад дараахь зөрчил илэрлээ. Аймгийн Засаг даргын 2013-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Хүн амын өсөлт, орон сууцны хэрэгцээтэй уялдуулан аймгийн орон сууцны хангамжийн түвшинг сайжруулах” зорилтын хүрээнд 5 суманд “сум бүрт 4 айлын орон сууц төсөл”-д Баян өнжүүл сум хамрагджээ. Аймгийн төсвөөс 2013 онд 40.0 сая төгрөг шилжих үлдэгдлээс санхүүжүүлж уг ажлыг эхлүүлэх хөрөнгийн асуудлыг шийдвэрлэсэн байна. Баян-Өнжүүл сум нь “Төсвийн тухай хууль”-ийн 63 дугаар зүйлд заасны дагуу иргэд, олон нийтийн санал авч, улмаар сумын ИТХ-аар сумын ОНХС-гаас төрийн албан хаагчдын орон сууц барихад 58.0 сая төгрөг зарцуулахаар шийдвэрлүүлсэн байна. Нийт 98.0 сая төгрөгийн хөрөнгийн эх үүсвэр шийдвэрлэгдсэн дээр 5 иргэний урьдчилгаа төлбөр 36.5 сая төгрөг төвлөрч нийт 134.5 сая төгрөгийн хөрөнгийн эх үүсвэр төвлөрчээ. Иргэдээс гэрээ байгуулалгүйгээр урьдчилгаа төлбөр авч төсвийн хөрөнгөтэй холилдуулан орон сууц барьсан нь данс бүртгэлд тусгах болон эзэмшлийн асуудлыг тодорхойгүй болгосон байна.

Аудитаар аймгийн Засаг даргын 2013-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлж буй ажлыг арилжааны зорилгоор хэрэгжүүлсэн Баян өнжүүл сумын холбогдох ажилтнуудад орон сууц олгох журам батлан, 174.5 сая төгрөгийн гэрээ байгуулж, төлүүлэн зөрчлийг арилгах албан шаардлага бичив.

2.2 ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх ажлуудад зарцуулах хөрөнгө, төсөвт өртгийг урьдчилан тооцсон, ТЭЗҮ, зураг, төсөв нь батлагдсан уу?

Сумдад иргэдийн саналын дагуу эрэмблэгдэж, хийгдэж байгаа ажлууд нь зураг, төсөвгүй байна.

2014 онд аймгийн хэмжээнд нийт 7581.4 сая төгрөгийн 340 төсөл, хөтөлбөр, хөрөнгө оруулалтын ажил хэрэгжсэн байна. Эдгээр ажлуудын 625.3 сая төгрөгийн 49 ажил нь үйл ажиллагааны зардал, урсгал зардлууд, үлдсэн 6956.1 сая төгрөгийн 291 ажил, хөрөнгө оруулалтын ажлууд байна. 6956.1 сая төгрөгийн ажлуудын дийлэнх нь зураг, төсөвгүй гэр худалдан авах, цэцэрлэгт хүрээлэн байгуулах, ногоон байгууламжийн хашаа, явган зам, талбай тохижуулах зэрэг ажлууд байна.

Сумдын ИТХ нь 2014 онд ОНХС-ийн хөрөнгөөр хийж гүйцэтгэх бараа, ажил, үйлчилгээний жагсаалт, түүнд зарцуулагдах хөрөнгийн эх үүсвэрийг батлахдаа хяналтын зураг, төсөвгүй ажилд хөрөнгө батласан байна. Учир нь дараа онд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх ажлыг иргэдийн саналын дагуу эрэмбэлж, сумын ИТХ-аар жагсаалтаа батлуулахад уг ажлуудын зураг, төсөв хийгдээгүй байдгаас сумын иргэдийн хурлаас батлагдсан мөнгөнд тааруулан, тухайн ажил гүйцэтгэхийн өмнө зураг, төсвөө хийлгэж, ажлаа гүйцэтгүүлдэг байна. Энэ нь “Төсвийн тухай хууль”-ийн 29.4-т “Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл арга хэмжээг тусгана” гэсэн заалт зөрчигджээ. Жишээлбэл:

-Дэлгэрхаан сум ерөнхий боловсролын сургуулийн ариун цэврийн байгууламжийг 75.5 сая төгрөгөөр, дотуур байрны ариун цэврийн байгууламжийн төхөөрөмж суурилуулах ажлыг 20.0 сая төгрөгөөр, нийт 95.5 сая төгрөгөөр хийж гүйцэтгэхээр сумын ИТХ-ын тогтоолоор баталж, гүйцэтгэлээр сумын ОНХСангаас 95.0 сая төгрөг, аймгийн Байгаль хамгаалах сангаас сумын ЗДТГазрын нөөц санд нэмэлт санхүүжилтээр 55.0 сая төгрөг, нийт 150.0 сая төгрөгөөр хийж гүйцэтгэсэн нь ИТХ-аар баталсан төлөвлөгөөнөөс 54.5 сая төгрөгөөр илүү зарцуулсан буюу эсвэл энэ хэмжээгээр дутуу төлөвлөсөн

-Монгол улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй “Сумдын төвлөрсөн дулаан хангамж” төсөл, арга хэмжээний хүрээнд Баян-Өнжүүл, Баянхангай сумын төвд халаалтын зуухны газар, дулааны шугам сүлжээ барих төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны гэрээг гүйцэтгэгч “Эл Си Би” ХХК нь сумын төвийн албан байгууллагуудыг нэгдсэн дулаан хангамжид холбож байгаатай холбогдуулан урьдчилсан зураг, төсөв хийгдээгүй 31.1 сая төгрөгийн өртөгтэй цэвэр усны шугамын ажил

-Эрдэнэ сум нь гэр хороолол тохижуулах ажилд 30.0 сая төгрөг батлажээ. Хяналтын зураг, төсөвгүй уг ажлыг гүйцэтгэхдээ 2 иргэнтэй 19.3 сая төгрөгийн гэрээ байгуулж, үлдсэн 12.0 сая төгрөгийг бэлнээр гаргаж зарцуулсан байна. Ажил гүйцэтгэсэн баримтанд 252 айлын хашааг засаж, янзлан гарын үсэг зуруулж хүлээлгэн өгсөн баримт байгаа боловч хяналтын төсөв байхгүйгээс ямар өртөгтэй ажлыг 30.0 сая төгрөгөөр гүйцэтгэсэн тодорхой бус байна.

- Мөн Эрдэнэ сум нь саун, халуун усны барилга, тоног төхөөрөмжийг 24.0 сая төгрөгийн гэрээ байгуулж гүйцэтгүүлэн, актаар хүлээж авчээ. Уг барилга нь хяналтын зураг төсөв байхгүй, шинээр ашиглалтанд орж байгаа, дэд бүтэц бүхий барилгыг, мэргэжлийн байгууллагын зөвшөөрөлгүй, барилга, байгууламж хүлээж авч ашиглалтанд оруулах, комиссын акт байхгүй ашиглалтанд оруулсан байна.

Аймгийн ИТХ-ын тодотголоор батлагдсан аймгийн ОНХС-аас 2014 оны ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх 3433.7 сая төгрөгийн 33 төсөл, арга хэмжээнд баталсан байна.

Аймгийн ОНХС-ийн 40 хувь буюу төвлөрсөн төсөвт хамаарах хөрөнгийн зарцуулалтад аудит хийхэд дараахь зөрчлүүд илэрлээ.Үүнд:

-Шинээр эхлэх 3 хөрөнгө оруулалтад 905.1 сая төгрөгийн санхүүжилт батлагдсан бөгөөд эдгээр ажлуудын зураг төсвийг 2014 онд хийж гүйцэтгэжээ.

-Зуунмод сумын төвийн хяналтын камер байршуулах ажилд нийтдээ 247.4 сая төгрөгийн өртөгтэй ажлын төсвийг төсөвчний эрхгүй аймгийн ЗДТГазрын Хөгжлийн бодлогын мэргэжилтэн төсвийг зохиосон нь байна.

-Төмсний борлуулалтын сүлжээг сайжруулах 150.0 сая төгрөгийн төсөл нь аймгийн ОНХС-аар хэрэгжүүлэхээр батлагдаж, суманд эрх шилжиж хэрэгжсэн байна. Уг төсөлд ямар үндэслэлээр 150.0 сая төгрөг батлагдсан эсэх нь тодорхойгүй

Мөн зураг, төсвийн үнэтэй холбоотой дараахь зөрчлүүд гарлаа.

-2014 онд тендер шалгаруулалт нь явагдсан Зуунмод сумын Баянхошуу баг, Баянцагаан сумын хүүхдийн цэцэрлэгийн барилгыг зураг, төсвийн ажлыг гүйцэтгэсэн ТГТ ХХК нь Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын 2012 оны 181 дүгээр тушаалаар батлагдсан “Барилгын төсөв зохиох дүрэм”-ийн 2.11-т “Барилгын төсөвт өртгийг тодорхойлоход барилгын ажил гүйцэтгэх ерөнхий нөхцлийг бүрдүүлэх зардал, төсөвт ашиг ба барилга угсралтын ажлын бусад лимитлэгдсэн зардлуудын нормативыг ашиглана. Үүнд: Зураг төсөл, хайгуулын ажлын жишиг үнэ тооцогдоно” гэсэн заалт зөрчигдөж төсөвт зураг, төсвийн үнэ нийт 29.9 сая төгрөгийг оруулж тооцоогүйгээс, уг зардал нь эргэж төлөгдөх боломжгүй болжээ. Мөн энэ онд тендер шалгаруулалт нь явагдах Сүмбэр сумын 13.4 сая төгрөгийн зураг төсвийн үнэ, аймгийн нэгдсэн эмнэлгийн барилгын өргөтгөлийн зураг төсвийн үнэ 15.9 сая төгрөг, нийт 29.3 сая төгрөгийн зураг төсвийн үнэ, ажлын төсөвт тусгагдаагүй байсанд тендерийн үнэнд оруулж тооцон, тендер шалгаруулалтыг явуулж, зураг төсвийн үнийг орон нутгийн хөгжлийн санд төлүүлэх албан шаардлага бичлээ.

-аймгийн театрын шинэ барилгын зураг, төсөвт аймгаас 94.2 сая төгрөг, геодезийн дүгнэлт гаргуулахад 4.5 сая төгрөг зарцуулжээ. Зураг, төсвийн ажил болон барилгын гүйцэтгэгчтэй ССАЖЯ-аас гэрээ байгуулж, ажил гүйцэтгүүлж, санхүүжилтийг олгосон байна. Зураг төсвийн ажлыг гүйцэтгэсэн “Кон инженерс” ХХК нь нийт 223.3 сая төгрөгийн

санхүүжилтийг авсан бөгөөд уг санхүүжилтэд аймгаас санхүүжилт нь хийгдсэн геодезийн 4.5 сая төгрөгийг яамнаас “Кон инженерс” ХХК-д шилжүүлсэн зөрчил илэрлээ. Мөн тус барилгын ажлыг гүйцэтгэгч “Рендербау” ХХК нь зураг төсвийн үнэ 224.8 сая төгрөг, экспертизийн үнэ 13.7 сая төгрөг, геологийн зардалд 4.5 сая төгрөг, нийт 242.9 сая төгрөгийн ажлын гүйцэтгэлээр санхүүжигдсэн байна. Аймгийн орон нутгийн хөгжлийн сангаас нийт 98.7 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон бөгөөд зураг, төсвийн үнэ 223.4 сая төгрөг байтал гүйцэтгэгч компани нь 242.9 сая төгрөгөөр санхүүжиж, 19.7 сая төгрөгийн санхүүжилтийг илүү авчээ. Аймгийн театрын барилгын зураг, төсөвтэй холбоотой нийт 122.6 сая төгрөгийн зөрчил илэрсэнд төлбөрийн акт бичигдлээ. Үүнд: аймгийн ОНХС-аас зарцуулагдсан 98.4 сая төгрөг, зураг төсвийн үнийн зөрүү 19.7 сая төгрөг, нийт 118.1 сая төгрөгийг “Рендербау” ХХК-аас, геодезийн үнэ 4.5 сая төгрөгийг “Кон инженерс” ХХК-аар төлүүл

-Цээл сум нь 46.6 сая төгрөгийн өртөгтэй сумын ногоон байгууламжийн төсөвт тусгагдснаар зураг төсвийн үнэ 0.9 сая төгрөг, Хужир сувилалын барилгын ажлын төсөвт тусгагдсанаар зураг төсвийн үнэ 1.7 сая төгрөг бөгөөд эдгээр ажлын төсвийг мэргэшсэн төсөвчин П.Баатарцогт хийж гүйцэтгэжээ. Гэвч мэргэшсэн төсөвчин П.Баатарцогтод сумын ногоон байгууламжийн 1.0 сая төгрөг, Хужир сувилалын барилгын ажлын зураг, төсвийн үнэнд 0.03 сая төгрөг, нийт 1.03 сая төгрөг илүү шилжүүлсэн, мөн гүйцэтгэгчээс зураг төсвийн үнэ 0.9 сая төгрөгийг тооцож аваагүй байна. 35.8 сая төгрөгийн өртөгтэй ахуй үйлчилгээ, нийтийн орон сууцны засварын ажлын төсөвт тусгагдсанаар зураг төсвийн үнэ 1.0 сая төгрөг бөгөөд мэргэшсэн төсөвчин Д.Одхүү хийж гүйцэтгэжээ. Гэвч мэргэшсэн төсөвчин Д.Одхүүд ахуй үйлчилгээ, нийтийн орон сууцны засварын ажлын зураг, төсвийн үнэнд 0.4 сая төгрөг илүү шилжүүлсэн, засварын ажлыг гүйцэтгэгч “Дархан үйлс” ХХК-аас зураг төсвийн үнэ 1.0 сая төгрөгийг суутгаж аваагүй байна. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан сумын ЗДТГ-ын барилгын зохиогчийн хяналтын зардалд ОНХС-аас 1.5 сая төгрөг шилжүүлсэн байсанд нийт 4.8 сая төгрөгийн акт бичигдлээ.

-Эрдэнэ сум нь Ундром ХХК-тай 7 ажлын зураг, төсөв боловсруулах 4.8 сая төгрөгийн гэрээ байгуулж, төсвийг тэргүүлэх төсөвчин Б.Баатарчулуун хийж гүйцэтгэсэн байна. Зураг төсвийн үнэнд 4.8 сая төгрөг шилжүүлсэн боловч

-гэрээгээр ажил гүйцэтгэсэн “Ундром” ХХК нь зураг, төсөв хийх тусгай зөвшөөрөлгүй

-зураг төсвийн үнэ нь эргэж төлөгдөөгүй,

-10.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй цэнгэлдэх хүрээлэнгийн ногоон байгууламжийн зураг төсвийг 0.3 сая төгрөгөөр, 18.0 сая төгрөгийн өртөгтэй худгийн ажлын зураг төсвийг 0.5 сая төгрөгөөр гүйцэтгэхээр гэрээ байгуулсан боловч зураг төсвийг хийгээгүй, санхүүжилтийг олгосон

-10.2 сая төгрөгийн нэг ижил төсөвтэй 6 гэрэлт цамхагийн зураг төсвийн үнийг тус бүрийг 250.0 мянган төгрөгөөр тооцож 1.5 сая төгрөг олгосон, нийт зураг төсвийн үнэ 4.8 сая төгрөгийн зөрчил илэрсэнд төлбөрийн акт бичигдлээ.

Үүнээс гадна зураг, төсөвгүй ажилд хөрөнгө батлагдаж, ТБОНӨХБАҮХАТухай хуулийн 8.4-т “тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт өртгийг үндэслэл болгоно” гэсэн заалт зөрчигдснөөс хөрөнгө оруулалтын ажил дутуу хийгдсэн байна. Тухайлбал: Цээл сумын 46.6 сая төгрөгийн өртөгтэй сумын ногоон байгууламжийн ажлыг 2014 онд сумын ИТХ-ын тогтоолоор батлагдсан 20.0 сая төгрөгөөр, Алтанбулаг сум нь 180.0 сая төгрөгийн өртөгтэй цэцэрлэгт хүрээлэнгийн ажлыг тухайн онд батлагдсан 60.0 сая төгрөгөөр санхүүжүүлж, тухайн онд нь багтааж дуусгах гэрээг байгуулж, ажил гүйцэтгүүлсэн боловч уг ажлуудын гүйцэтгэл дутуу, данс бүртгэлд тусгагдаагүй байна.

Өмнөх оны 12 сард аймаг, сумын хурлаар ОНХС-аас батлагдаж байгаа хөрөнгө оруулалт нь жагсаалтаар зураг, төсөвгүй, ажлуудын санхүүжилтийг батлаж, батлагдсны дараа зураг төсвийг хийдэг нийтлэг зөрчил байна.

Аудитын явцад зураг, төсөвтэй холбоотой гарсан зөрчлийг арилгах зорилгоор төсвийн тухай хуулийн 29.4 дэх заалтыг хэрэгжүүлж ажиллах зөвлөмжийг хүргүүлээ.

2.3 ОНХС-ийн хөрөнгийг ИТХ, багийн ИНХ-аар дэмжигдээгүй хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр төлөвлөсөн, зарцуулсан эсэх?

Сумын ИТХ, багийн ИНХ-аар дэмжигдээгүй 172.8 сая төгрөгийн хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээ хэрэгжсэн байна.

ОНХС-г Төсвийн тухай хууль, ТБОНӨХБАУХА тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн дагуу нийт сумдууд багийн иргэдийн нийтийн хурлаар хэлэлцэн иргэдийн саналыг авч эрэмбэлэн нэгтгэж, 2014 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр сумдын ИТХ-ын тогтоолоор тодотгон баталж, төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажилласан байна.

Гэвч сумдын ОНХС-ийн хөрөнгийг ИТХ, багийн ИНХ-аар дэмжигдээгүй хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр төлөвлөн, зарцуулсан зөрчил зарим сумдад байна. Тухайлбал:

- Зуунмод суманд 24.8 сая төгрөгийн нийтийн бие засах газар, 50.0 сая төгрөгийн ногоон барилгын /континераар барьсан хаус/ ажил, 30.0 сая төгрөгийн сумын ЗДТГазрын иргэдэд үйлчлэх танхимын засвар шинэчлэл гэсэн 3 төсөл арга хэмжээг БИНХ-ын хурлаас иргэдийн саналыг эрэмбэнд ороогүй байхад ИТХ-аар оруулан батлуулж, ОНХС-ийн төлөвлөгөөнд тодотгон тусгасан

- Мөнгөнморьт сум ЗДТГазрын гадна талбайн тохижилтын ажлыг хийж гүйцэтгэх явцад 3.4 сая төгрөгөөр чулуун арслан суурилуулах ажлыг хийж гүйцэтгүүлсэн нь иргэдийн саналын эрэмбэнд ороогүй, ИТХ-аар нэр зааж батлагдаагүй ажлыг тендерийн хэмнэлтээр хийж гүйцэтгүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 45-р зүйлийн 45.2.1, 45.2.2, 45.2.3, 60-р зүйлийн 60.3.6 дахь заалт, Сангийн сайдын 2012 оны 12 сарын 27-ны өдрийн 290-р тушаалын хавсралтаар батласан Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн журмын 3-р зүйлийн 3.25, 3.26 дахь заалтуудыг тус тус зөрчсөн байгаад төлбөрийн акт тогтоов.

- Баянжаргалан сум ОНХСангийн хөрөнгөөр 2014 онд хийгдэх ажлын иргэдийн саналыг эрэмбэлсэн жагсаалтын дэс дарааллыг мөрдөлгүйгээр 20.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй шагайн байрыг барих, эрэмбэлсэн жагсаалтанд байхгүй англи хэлний сургалтанд 0.3 сая төгрөг, ахмадаа хүндлэх арга хэмжээнд 2.5 сая төгрөг, цэцэрлэгт байгалийн булан байгуулахад 0.7 сая төгрөг, эх үрсийн баярын арга хэмжээнд 1.1 сая төгрөг, залуучуудын зөвлөлгөөнд 0.8 сая төгрөг, нийт 5.4 сая төгрөгийг зориулалт бусаар төлөвлөн зарцуулсан байсанд зориулалтын дагуу зарцуулах албан шаардлага хүргүүлэв.

- Баянцогт сум төвийн усан сангийн ус түгээгч, ус зөөгчийн цалин. шимтгэлд 6.4 сая төгрөгийг төлөвлөн зарцуулж, Баянцагаан сум хогийн машины жолоочийн цалинд 2.6 сая төгрөг, малчны цалинд 4.8 сая төгрөг, Аргалант сум засаг даргын орлогчийн томилолтын зардалд 1.0 сая төгрөг, Батсүмбэр сум гудамжны гэрэлтүүлгийн цахилгааны зардалд 5.6 сая төгрөг, сумын ИТХ-аас томилсон хяналтын зөвлөлийн зардалд 2.1 сая төгрөгийг зарцуулжээ. Энэ нь орон нутгийн удирдлагыг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах урсгал зардлыг тус сангаас гаргасан нь Төсвийн тухай хуулийн 60-р зүйлийн 60.3.6 дахь заалт, Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтын 6-р зүйлийн 6.3 дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна.

- Эрдэнэ сум нь ОНХС-аас 10 хүнд томилолтын зардалд 1.4 сая төгрөг олгосонд акт бичлээ.

- Баян сум эрэмбэнд ороогүй 5 гэр авахад 30.0 сая төгрөгийг сумын хурлаар батлуулж, худалдан авсан.

Аудитаар иргэдийн саналын эрэмбэнд ороогүй, сумын ИТХ-аар батлагдаагүй нийт 172.8 сая төгрөг зарцуулсан зөрчил илэрсэнд зөвлөмж, акт, албан шаардлага бичлээ.

2.4 ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээг ИТХ-аас баталсан жагсаалт болон холбогдох журмын дагуу зарцуулсан уу?

ОНХС-д төвлөрч байгаа хандивын орлогыг тухайн хандив өгч байгаа иргэн, аж ахуйн нэгж нь тодорхой зорилгоор өгч байгаа тул тухайн төсөл, арга хэмжээнд зарцуулагдаж, ОНХС-ийн журмын дагуу зарцуулагдахгүй байна.

ОНХС-ийн хөрөнгөөр 2014 онд аймгийн хэмжээнд нийт 399 төсөл, арга хэмжээнд 9621.1 сая төгрөг зарцуулахаар аймаг, сумын ИТХ-аас жагсаалтаар батлагдаж, 7581.4 сая төгрөгийн 340 ажил хэрэгжсэн байна. Сумдад хэрэгжсэн нийтлэг арга хэмжээнүүдийг дурдвал:

-Төсвийн тухай хуулийн 60.3.3-т “үндэсний их баяр наадмаас бусад баяр наадам, ойн арга хэмжээ, шашны зан үйлийн болон ёслолын зардалд зарцуулахыг хориглоно” гэсэн заалт, мөн 2010 оны 271 тоот тогтоолын дагуу сум бүр 5.0 сая төгрөгийг сумын баяр наадмын зардалд батлуулж, нийт 135.0 сая төгрөгийг зарцуулсан.

-Мөн хуулийн 60.3.1-т “орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргээс бусад хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхийг хориглоно” гэсэн заалтын дагуу сум төсвийн тухай хуулиар өөрийн төсвөөр бие даан хэрэгжүүлэх гудамж талбайн гэрэлтүүлэг, цэвэрлэгээ, хог хаягдал, малжуулах, нийтийн эзэмшлийн гэрэлтүүлгийн урсгал засвар, сумын тохижилт, цэцэрлэгжүүлэлт, явган зам, хүүхдийн тоглоомын талбай барих зэрэг чиг үүргийг ОНХС-ийн хөрөнгөөр хийж гүйцэтгэсэн байна. Жишээлбэл:

-Баянчандмань сум нь жагсаалтаар хог хаягдал цэвэрлэх, тээвэрлэх зардалд 18.7 сая төгрөг, төвийн гудамжны гэрэлтүүлэг засварт 7.4 сая төгрөг, нийт 26.1 сая төгрөг батлагдаж, хог хаягдалд 18.5 сая төгрөг, гэрэлтүүлгийн засварын зардалд 6.8 сая төгрөг, нийт 25.4 сая төгрөг, Жаргалант сум нь цэвэр орчин, хог хаягдлын хэсгийн үйлчилгээний зардалд 26.6 сая төгрөг батлагдаж, 25.0 сая төгрөг зарцуулсан байна. Үүнд: ажилчдын цалинд 18.8 сая төгрөг, шатахуунд 6.2 сая төгрөгийг зарцуулжээ.

Аймгийн ОНХС-аас тодотголоор 33 төсөл, арга хэмжээнд 3433.7 сая төгрөгийг зарцуулахаар жагсаалтаар батлагджээ. Гүйцэтгэлээр 2736.2 сая төгрөгийн санхүүжилтээр 26 хөрөнгө оруулалтын ажил хийсэн байна. Аудитын явцад дараахь зөрчил илэрлээ. Үүнд:

-Аймгийн төрийн ба төрийн бус байгууллагуудын 2 дугаар байрны засварт 127.2 сая төгрөг батлагдаж, 322.7 сая төгрөг зарцуулагдаж, 195.5 сая төгрөг батлагдсан төсвөөс илүү зарцуулсан,

-“Солонго цогцолбор” буюу кинотеатрын барилгад урд онд 399.1 сая төгрөг, 2014 онд 50.0 сая төгрөг, нийт 449.1 сая төгрөг батлагдаж, 102.1 сая төгрөг, нийт 297.6 сая төгрөгийг батлагдсан төсвөөс хэтрүүлж зарцуулжээ.



Төрийн ба төрийн бус байгууллагын ордон



“Солонго цогцолбор”

-81.4 сая төгрөгийн зураг, төсвийн ажил, жишиг хороололын усан сангийн 24.4 сая төгрөг, нийт 105.8 сая төгрөгийн ажлууд нь жагсаалтаар батлагдаагүй хийгдсэн байна

-аймгийн хөрөнгө оруулалтын жагсаалтад 10 сумын цэцэрлэгт 75.0 сая төгрөгийн тавилга, тоног төхөөрөмж бэлтгэх ажил батлагджээ. Аймагын Засаг даргын 2014 оны а/63 тоот “Захиалагч томилох тухай” захирамжаар “Цэцэрлэгүүдийн тавилга, тоног төхөөрөмжийн шинэчлэл” ажлын захиалагчаар АЗДТГ-ыг томилжээ. Гэвч АЗДТГ-ын дарга биш аймгийн Хөгжлийн бодлогын хэлтсийн дарга, мэргэжилтэн нар нь “БОНН” ХХК-тай 10 сумын цэцэрлэг тус бүрт 7.5 сая төгрөгийн зөөлөн эдлэл, сургалтын хэрэглэгдэхүүн бэлтгэх гэрээг байгуулж, 75.0 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. Тус ажил нь батлагдсан төсвийн зориулалтыг өөрчилж, төсвийг хувааж жижиглэн, тендер шалгаруулалт явуулаагүй, шууд гэрээ байгуулсан боловч гэрээ нь харьцуулалтын аргаар хийгдсэн ажлын гэрээ байна. Энэ нь “Төсвийн тухай хууль”-ийн 16.5.5-д “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 24.4-т “төсвийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол санхүүжилт гаргахыг хориглоно”, Сангийн сайдын 2012 оны 290 дүгээр тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн журам”-ын 3.25-д “Барилга, байгууламж, их засварын зардлыг хооронд нь шилжүүлэх, батлагдсан нэр, байршлыг солих, хүчин чадлыг өөрчлөх, хуулиар батлагдсан төсөвт өртгийг хэтрүүлэн тендер зарлах, гэрээ байгуулах, санхүүжүүлэхийг хориглоно”, ТБОНӨХБАҮХАТухай хуулийн 8.4-т “тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно”, 8.5-д “энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно” гэсэн заалтууд зөрчжээ. Уг ажил нь санхүүжилтээ бүрэн авсан боловч захиалагч нь гэрээний хэрэгжилтэнд хяналт тавиагүй, гэрээгээ дүгнээгүй, гэрээ байгуулсан сумд нь 32.7 сая төгрөгийн бараа, материалыг хүлээж аваагүй, данс бүртгэлд тусгаагүй, санхүүгийн анхан шатны баримт байхгүй зөрчил илэрлээ.

Зарим сумд нь тухайн онд батлагдаагүй төсөл, арга хэмжээг санхүүжүүлсэн нь урд онд хэрэгжүүлэхээр батлагдсан боловч тухайн ондоо хийж гүйцэтгээгүй төсөл арга хэмжээнүүд байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д “Төсвийн жил нь тухайн оны 1 дүгээр сарын 01-ний өдөр эхэлж, тухайн оны 12 дугаар сарын 31-ний өдөр дуусгавар болно”, 7.3-д “Төсвийг нэг жилээр баталж, тайлагнах бөгөөд батлагдсан төсвийг сар, улирлаар хуваарилан, хэрэгжилтийг зохион байгуулна” гэсэн заалтыг зөрчсөн байна. Үүнд:

- Борнуур сум нь 2014 онд хийгдэх ажлын жагсаалтад орж, хурлаар батлагдаагүй, урд онд батлагдсан, хог цэвэрлэх ажилд 12.4 сая төгрөг зарцуулсан, Баяннөжүүл сумын ОНХСангаас 2014 онд орон сууц барихаар батлагдсан эх үүсвэрээс 40.0 сая төгрөгийг илүү зарцуулсан нь урд онд батлагдсан 57.2 сая төгрөгнөөс зарцуулсан.

- Алтанбулаг сум нь 2014 онд сумын ИТХ-ын тодотголоор 194.3 сая төгрөгийн 8 төрлийн ажил гүйцэтгэхээр батлагдсан боловч 257.8 сая төгрөгийн 14 төрлийн ажлыг хийж гүйцэтгэсэн нь өмнөх онд жагсаалтаар батлагдсан буюу тухайн онд сумын ИТХ-ын тогтоолоор батлагдаагүй, 63.5 сая төгрөгийн ажлыг хийж гүйцэтгэсэн.

- Сэргэлэн, Баянхангай, Дэлгэрхаан, Аргалант сумдууд ИТХ-аар баталсан ОНХсангийн хөрөнгөөр хийж гүйцэтгэх ажлыг тухайн тайлант жилд нь хийж гүйцэтгэхгүй байснаар өмнөх оноос хийгдээгүй шилжиж ирсэн ажлыг хийж гүйцэтгэх, 2014 онд төлөвлөгдсөн ажлыг бүрэн хийж гүйцэтгээгүйгээс сумын ОНХСангийн дансны үлдэгдэл ихтэй гарсан байна.

Дээрхи 115.9 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлээ.

Мөн сумын 90 жилийн ойн баярыг тэмдэглэсэн сумдууд нь сумын ойг тэмдэглэхтэй холбогдуулан иргэдээс ач холбогдол багатай зарим хөрөнгө оруулалтуудад санал асуулга авч, эрэмбэлсэн жагсаалтад оруулсан нь “Төсвийн тухай хууль”-ийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах” гэсэн заалт зөрчигдсөн байна.. Жишээлбэл: Зарим сумдууд өндөр үнэтэй, олон тооны гэр бэлтгэжээ. Үүнд: Баян сум нь 55.0 сая төгрөг буюу ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн ажлын 31 хувь нь 6 гэр авахад, Аргалант сум 25.0 сая төгрөгөөр 1 гэр, Батсүмбэр сум 62 сая төгрөгөөр 2 гэр, Бүрэн сум 29.0 сая төгрөгөөр 1 гэр худалдан авчээ.



Баян сумын 25 сая төгрөгийн гэр



Батсүмбэр сумын 50 сая төгрөгийн гэр

ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээг тухайн шатны ИТХ-аас баталсан жагсаалт болон холбогдох журмын дагуу зарцуулсан эсэхэд шалгалт хийхэд батлагдсан төсөв хэтрүүлэх буюу зориулалтын бус зарцуулагдсан зөрчлүүд гарлаа. Үүнд:

-Алтанбулаг сумын ОНХС-аас сумын хогийн цэг тохижуулахад 15.0 сая төгрөг батлагджээ. Нийт 19.5 сая төгрөгийн өртөгтэй ажлын үлдэгдэл 4.5 сая төгрөгийг байгаль хамгаалах сангаас зарцуулах шийдвэр гарсан боловч бүх санхүүжилтийг ОНХС-аас хийж батлагдсан төсвийг 4.5 сая төгрөгөөр хэтрүүлж зарцуулсан байна. Мөн Сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн 2014 оны 06 сарын 05-ны өдрийн 35 тоот тогтоолоор сумын төсвийн давсан үлдэгдэл 13.9 сая төгрөгийг 2-р Богдын мэндэлсний 290 жилийн ойд зарцуулахаар батлажээ. Үүнд намтар хэвлүүлэх зардалд 4.0 сая төгрөг батлагдсан боловч ОНХС-аас 2.0 сая төгрөг зарцуулсанд 6.5 сая төгрөгийн акт бичигдлээ.

2014 онд аймгийн ОНХС-д нийт 1059.7 сая төгрөгийн бусад орлого төвлөрсний 650.4 сая төгрөг нь хандивын орлого, 332.3 сая төгрөгийн газрын дуудлага худалдааны анхны үнэ байна. Төсвийн тухай хуулийн 60.2.5-д “тухайн орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор олгосон дотоод, гадаадын хандив, тусламж нь орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэр байна” гэж заасан боловч тухайн хандивлагч аж ахуйн нэгж байгууллага нь сумдын 90 жилийн ойд, наадмын зардалд гэж тодорхой зориулалтаар хандив өгдгөөс орон нутгийн хөгжлийн сангийн журмын дагуу зарцуулагдахгүй, тухайн арга хэмжээнд зарцуулагдаж байна.

Тайлант онд тэмдэглэлт түүхэн ой болоогүй Баянчандмань сумын баяр наадмын зардалд 2.4 сая төгрөгийн хандив өгч, батлагдсан 5.0 сая төгрөг нь 7.4 сая төгрөг болж хэтэрчээ.

Хандивын орлогыг зарцуулахад сумын ИТХ-аас ой тэмдэглэн өнгөрүүлэх тухай зардлын төсвийг батласан тогтоол гарч, ОНХС-д төвлөрүүлэн, сумын ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтээр дамжуулан зарцуулж, тайлагнагдаж байна. 2014 онд сумын 90 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлсэн Батсүмбэр сум 65.1 сая төгрөг, Баянцагаан 40.4 сая төгрөг, Бүрэн 127.9 сая төгрөг, Өндөрширээт 130.8 сая төгрөг, Сэргэлэн 134.3 сая төгрөг, Угтаал 61.9 сая төгрөгийн хандивын орлого төвлөрч сумын ИТХ-ын тогтоолоор зарцуулагдсан байна.

Угтаал сум нь 90 жилийн ойн арга хэмжээний зардлыг сумын ИТХ-аараа батлуулсан боловч хандивын орлого нь төлөвлөсөн хэмжээнд төвлөрөөгүйгээс дараахь зөрчил гарчээ. Сумын 90 жилийн ойн хандивт 69.2 сая төгрөг, газрын дуудлага

худалдааны анхны үнийн буцаалт 2.2 сая төгрөг, газрын дуудлага худалдааны анхны үнэ 48.8 сая төгрөг ОНХС-д төвлөрчээ. 2013 оны аймгийн ИТХ-ын 6 дугаар хуралдааны /12 сарын 03/ 1 тоот тогтоолын 11-т “Газрын тухай хуулийн зарим заалтын хэрэгжилтийг хангах тухай аймгийн ИТХ-ын Тэргүүлэгдчийн 2012 оны 77 дугаар тогтоолын дагуу төсөвт төвлөрөх орлогын 50 хувийг аймгийн “Орон нутгийн хөгжлийн сан”-д, 50 хувийг тухайн сумын “Орон нутгийн хөгжлийн сан” болон төсөвт хуваарилан олгохоор тогтоосугай” гэсэн заалтыг зөрчиж 48.8 сая төгрөгийн газрын дуудлага худалдааны анхны үнийг сумын ОНХС-д төвлөрүүлж зарцуулсан, сумын 90 жилийн ой болж байгаатай холбогдуулан хурлаар батлагдаагүй 15.6 сая төгрөгийн засварын ажил, зураг төсөв болон нохой устгалын 5 ажлыг хийж гүйцэтгэжээ. Угтаал сумын эдгээр зөрчилд 24.4 сая төгрөгийн акт бичигдэж, 15.6 сая төгрөгөнд зөвлөмж хүргүүллээ.

2.5 ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа холбогдох хууль, тогтоомжийг мөрдсөн үү?

Сум, орон нутагт үнэлгээний хороонд ажиллаж байгаа АЗ гэрчилгээтэй иргэдийн мэдлэг дутмагаас худалдан авах ажиллагааны хууль зөрчигдөж, ХАА-ны албаны дарга нь хууль зөрчжээ.

Аймгийн болон 27 сумдын ОНХСангийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр батлагдсан нийт 399 төсөл арга хэмжээнээс хэрэгжсэн 293 хөрөнгө оруулалтын ажлуудын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа нээлттэй тендер шалгаруулалтын аргаар 10, харьцуулалтын арга буюу олон нийтийн оролцооны аргаар 109, шууд гэрээ байгуулж гүйцэтгүүлсэн 174 ажил байна.

Сум, орон нутагт ОНХС-ийн хөрөнгийн эх үүсвэрээр хийгдэж байгаа бараа, ажил, үйлчилгээний худалдан авах ажиллагааг зохион байгуулах үнэлгээний хороонд ажиллаж байгаа ТБОНӨХБАҮХАТухай хуулийг хэрэгжүүлэх АЗ гэрчилгээтэй иргэдийн мэдлэг хангалтгүйгээс худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй байна. Үүнд:

-Жаргалант, Дэлгэрхаан, Сэргэлэн, Баянжаргалан, Баянхангай, Батсүмбэр сумдууд ТБОНӨХБАҮХА тухай хууль болон түүнийг дагалдаж гарсан журмуудыг баримтлах, тендерийн баримт бичгийг боловсруулан хэрэгжүүлэх тал дээр хангалтгүй ажилласан

-Баяннөжүүл сум нь “Дөрвөн айлын орон сууц болон бэлчээрийн гүн өрмийн 3 худаг гаргах” ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах урилгыг “Өнөөдөр” сонинд нийтэлж, Засаг даргын захирамжаар томилогдсон үнэлгээний хороо хуралдаж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан байна. Тендер шалгаруулалтад “Түмэн сүүн гэрэл” ХХК буюу 1 компани материалаа ирүүлж, 39.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй барилгыг тус бүр нь 34.9 сая төгрөгөөр, нийт 5 барилгыг 174.5 сая төгрөгөөр барьж ашиглалтад оруулахаар гэрээ байгуулж, гэрээний хугацаанд хийж гүйцэтгэсэн байна. Тус компани нь “Барилгын тусгай зөвшөөрөл”-гүй, өмнө хийж гүйцэтгэсэн ажлын туршлага байхгүй, ТБОНӨХБАҮХАТухай хуулийн 14 дүгээр зүйлд заасан ерөнхий нөхцлийг хангаагүй байхад хууль зөрчиж, гэрээ байгуулж, ажлыг гүйцэтгүүлсэн байна.

Тусгай зөвшөөрөлгүй компанийн барьсан барилгыг мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн “Барилга байгууламжид тавих шаардлага”-ыг хангасан тухай дүгнэлт гарч сумын Засаг даргын захирамжаар томилогдсон “ажлын хэсэг” гарч актаар хүлээж авсан байна. Сумын Засаг даргын захирамжаар байгуулагдсан үнэлгээний хороо нь ТБОНӨХБАҮХАТухай хуулийн 47.2-д заасан чиг үүрэгт байхгүй эрх эдэлж анхны хуралдаанаар дөрвөн айлын орон сууцны хөрөнгийн эх үүсвэр шийдвэрлэгдсэн учраас урьдчилгаа төлбөр авч 5 дахь орон сууцны хөрөнгийн эх үүсвэр болон барих асуудлыг шийдвэрлэсэн байна.

- Мөн сумын ИТХ-ын тогтоолоор “Хогийн цэгийг хашаажуулах” ажилд 30.0 сая төгрөг батлагдаж, “Соёолж төгөлдөр” ХХК-аар 15.0 сая төгрөгийн гэрээ байгуулж, гүйцэтгүүлэн, актаар хүлээж авсан байна. Энэ нь “Төсвийн тухай” хуулийн 29.4-т “Хөрөнгө оруулалтын төсөвт ТЭЗҮ хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл арга хэмжээг тусгана”, “ТБОНӨХБАҮХАТухай хуулийн 8 дугаар зүйл, 3Г-ын 2013 оны 68 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Шууд

худалдан авч болох төсөвт өртөгийн дээд хязгаар ажил 10 сая төгрөг” байна гэсэн заалтыг зөрчжээ.

-Жаргалант сумын ЗДТГазар “Төмсний борлуулалтын сүлжээг сайжруулах” төсөл хэрэгжүүлэх ТЭЗҮ болон зураг төсөв боловсруулах зөвлөх үйлчилгээний 150.0 сая төгрөгийн ажлыг тендер зарлалгүйгээр гэрээ шууд байгуулан “Монголын хөдөөг шинэчлэх фермерүүдийн холбоо”-нд 138.5 сая төгрөгийг шилжүүлж, мөн тус төслийн ТЭЗҮ боловсруулахад хийсэн судалгааны ажлын нэгжийн үнэлгээ бодит байдлаас хэт өндөр байгаа тул холбогдох мэргэжлийн байгууллагаар экспертиз буюу хөндлөнгийн магадлалын үнэлгээ хийлгэх, зөрчлийг арилгуулах албан шаардлага бичив.

-Дэлгэрхаан сум 149.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Ерөнхий боловсролын сургууль, дотуур байрны ариун цэврийн байгууламжийг хийж гүйцэтгэхээр аймгийн худалдан авах ажиллагааны албаны даргын ирүүлсэн албан бичгийг үндэслэн “Монгол дайван” ХХК-тай шууд гэрээ байгуулах аргаар хийхээр шийдвэрлэсэн нь ТБОНӨХБАҮХАА-ны тухай хуулийн 6, 8.1.1, 8.2, 17, 21.1.1, 21.1.2, 52.1.12, Төсвийн тухай хуулийн 24-р зүйлийн 24.4 дэх заалт, Засгийн газрын 2013 оны 68-р тогтоолын заалтуудыг зөрчсөн байна. Ийнхүү аймгийн худалдан авах ажиллагааны албаны даргын гарын үсэгтэй албан тоот бичгээр тус компанитай гэрээ шууд байгуулах үүрэг чиглэл өгч байгаа нь хууль тогтоомж зөрчсөн төдийгүй цаана нь ямар нэгэн ашиг сонирхол байгаа эсэх, зарим ариун цэврийн байгууламжийн далд ажлын үнэлгээ тодорхойгүй, тавьсан зарим тоног төхөөрөмжийн нэгжийн үнэ өнөөгийн зах зээлийн үнээс харьцангуй өндөр үнээр авч бэлтгэснээр гүйцэтгэлд тусгасан зэргийг холбогдох байгууллагад нь асуудал болгон тавьж шалгуулах нь зүйтэй гэж үзлээ. Аймгийн худалдан авах ажиллагааны албаны 2014 оны 9 сарын 23-ны өдрийн А/112 албан бичигт “...нээлттэй тендер зохион байгуулах нь зүйтэй байна...гэвч цаг хугацааны хувьд бага байгаа тул “Монгол дайван” ХХК-тай гэрээ шууд байгуулахад ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 34.2 дахь заалтыг баримтлан гэрээ байгуулах нь зүйтэй юм” гэж ирүүлснийг үндэслэн сумын Засаг даргын 99-р захирамжаар байгуулагдсан үнэлгээний хороо 2014 оны 9 дүгээр сарын 30-нд хуралдаж “Монгол дайван” ХХК-тай шууд гэрээ байгуулах аргаар хийж гүйцэтгүүлжээ.

-Сэргэлэн сум ТБОНӨХБАҮХАТухай хуулийн дагуу тендер зарлан сонгон шалгаруулалгүй, гэрээ шууд байгуулж 4 айлын орон сууцны үнийн 50 хувь гэж 40.0 сая төгрөгийг “Тусгал төв” ХХК-д шилжүүлж, хийгдэх ажлын хяналтын төсөв, ажлын явцын гүйцэтгэл, ажил хүлээн авсан акт баримт байхгүй байхад гүйцэтгэлээр тайлагнаж, санхүүгийн тайланд дансны авлагаар тусгаагүй, газар дээр очиж үзэхэд 40.0 сая төгрөгийн ажлыг хийж гүйцэтгүүлээгүй байсан тул төлбөрийн акт тогтоов.



Сэргэлэн сум 4 айлын орон сууц бариулахаар гүйцэтгэгч компанитай гэрээ байгуулж 50 хувийн урьдчилгаа 40,0 сая төгрөгийн ажлыг хийснээр тайлагнасан ажлын гүйцэтгэлийн байдал.

-Баянхангай сум барилга барих, засварлах тусгай зөвшөөрөлгүй, мэргэжилтэй ажилчдаар хийж гүйцэтгүүлэх шаардлагатай ажлуудад Эмэгтэйчүүдийн зөвлөл болон бусад төрийн бус байгууллагуудыг худалдан авах ажиллагаанд оролцуулан гүйцэтгэгчээр сонгон шалгаруулж, барилга байгууламж барих, засварлах зэрэг ажлуудыг хийлгэжээ.

-Батсүмбэр сум ТБОНӨХБАҮХАА-ны тухай хуулийн хэрэгжилт, тендерийн баримт бичгийг шалгаж үзэхэд үнэлгээний хорооны шаардлагад нийцсэн тендер байхгүй гэсэн шийдвэрийг зөрчин захиалагч сумын ЗДТГазрын дарга нь гүйцэтгэгч болох “Хүннү гэр” ХХК-тай гэрээ шууд байгуулан Ёслол хүндэтгэлийн өргөөг барьж байгуулах худалдан авах ажиллагааг явуулж 48.0 сая төгрөгөөр гүйцэтгүүлсэн

-Жаргалант сум нь 15.2 сая төгрөгийн төсөвтэй зохиомол хээлтүүлгийн пункт барих ажлын гэрээг 0.9 сая төгрөгөөр хэтрүүлж, 16.2 сая төгрөгийн гэрээ байгуулж ажил гүйцэтгүүлсэн нь ТБОНӨХБАҮХАТухай хуулийн 30.1.3-т “шаардлагад нийцсэн бүх тендерийн үнэ захиалагчийн тооцсон төсөвт өртгөөс 5-аас дээш хувиар хэтэрсэн тохиолдолд тендерээс татгалзах” гэсэн заалт зөрчигдсөн байсанд 0.9 сая төгрөгөнд акт бичигдлээ.

-Зуунмод суманд 24.8 сая төгрөгийн нийтийн бие засах газар, 50.0 сая төгрөгийн ногоон барилгын /континераар барьсан хаус/ ажлыг хийж гүйцэтгүүлэхээр тендер зарлалгүй гэрээ шууд байгуулсан, тус сумын ЗДТГазрын иргэдэд үйлчлэх танхимын засвар шинэчлэлийг 30.0 сая төгрөгөөр хийж гүйцэтгүүлэхээр 3-4 гүйцэтгэгчтэй захиалагчийн зүгээс үнэлгээний хороо байгуулалгүй, тендерийн бичиг баримт боловсруулалгүйгээр гүйцэтгэгчтэй сумын ЗДТГазрын дарга Ж.Ганбат шууд гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн нь ТБОНӨХБАҮХАА-ны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 19 дүгээр зүйлийн 19.1, 19.2, 46 дугаар зүйлийн 46.1.3, 47 дугаар зүйлийн 47.2.2, Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4 дэх заалтуудыг тус тус зөрчсөн байна.

-Төрийн болон төрийн бус байгууллагуудын ордны нийт 480.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй засварын ажилд нийт 472.1 сая төгрөгийн ажил гүйцэтгэх гэрээ байгуулагдаж, 437.9 сая төгрөгийн санхүүжилт олгогдсон байна. Тус барилгын ажилд 127.2 сая төгрөг батлагдсан бөгөөд дээврийн засварын 67.2 сая төгрөг, гадна фасадны 60.0 сая төгрөгийн санхүүжилт байна. Засварын ажлын хурлаар батлагдсан 2 ажилд харьцуулалтын аргаар гүйцэтгэгчийг шалгаруулж 116.9 сая төгрөгийн гэрээ байгуулагдаж, 10.3 сая төгрөгийн хэмнэлт гарчээ. Батлагдсан 2 ажлыг гүйцэтгэсэн 2 компаниас гадна 8 компанитай 306.3 сая төгрөгийн шууд гэрээг байгуулж ажил гүйцэтгүүлсэн байна. Энэ нь ТБОНӨХБАҮХАТухай хуулийг зөрчжээ.

2.6 ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн арга хэмжээг бүртгэлд тусгах ажлыг хуулийн дагуу зохион байгуулсан уу?

ОНХС-аар хэрэгжсэн нийт 894.6 сая төгрөгийн ажлыг данс бүртгэлд тусгаагүй байна.

ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн арга хэмжээг бүртгэлд тусгах ажлыг төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, бусад дүрэм журмын дагуу холбогдох данс бүртгэлд тусган ажилласан байна. Гэвч аудитын явцад ОНХСангийн хөрөнгөөр санхүүжүүлсэн бараа ажил үйлчилгээг санхүүгийн тайлангийн данс бүртгэлд бүрэн тусгах ажлыг хууль, дүрмийн дагуу хийж гүйцэтгээгүй зарим зөрчил байгааг дурдвал:

-Жаргалант сумын ЗДТГазар “Төмсний борлуулалтын сүлжээг сайжруулах” төсөл хэрэгжүүлэх ТЭЗҮ болон зураг төсөв боловсруулах зөвлөх үйлчилгээний 150.0 сая төгрөгийн ажлыг тендер зарлалгүйгээр гэрээ шууд байгуулан “Монголын хөдөөг шинэчлэх фермерүүдийн холбоо”-нд 138.5 сая төгрөгийг шилжүүлж, уг мөнгийг хөрөнгө, авлагаар буюу урьдчилж гарсан зардлын дансанд тусган бүртгэлгүй төсвийн шууд зардал буюу төсөл арга хэмжээний зардалд тусган тайлагнасан,



Жаргалант сумын “Төмсний борлуулалтын сүлжээг сайжруулах” 150.0 сая төгрөгийн зөвлөх үйлчилгээний төсөл

-Зуунмод сумын замын дагуу дүрс бичлэгийн камер суурьлуулах ажлын санхүүжилтийн 80 хувь болох 197.9 сая төгрөгийг олгож ажлаа эцэслэн дуусгаагүй байхад авлагаар тусган харуулаагүй,

-Баяндэлгэр сум ЗДТГ-ын гражийн барилга бариулахаар гүйцэтгэгч байгууллагад ажлаа эхлээгүй байхад гэрээний урьдчилгаа 12.0 сая төгрөг, Сэргэлэн сум 4 айлын орон сууцны үнийг гүйцэтгэгч байгууллагад ажлаа эхлээгүй байхад гэрээний урьдчилгаа 40.0 сая төгрөг шилжүүлээд ажлаа хийж гүйцэтгүүлээгүй, дансны авлагаар бүртгээгүй,

-Баян сум нь ОНХС-аас 10.0 сая төгрөг /3 сая төгрөг хандив/ зарцуулж гүйцэтгүүлсэн 13.0 сая төгрөгийн өртөгтэй цэнгэлдэх хүрээлэнгийн цахилгааны шугам тавих ажил, 4.5 сая төгрөгийн морь барианы талбай тохижуулах ажлуудыг актаар хүлээж аваагүй, данс бүртгэлд тусгаагүй.

-Борнуур сум нь ногоон төгөл байгуулах хашаанд 24.4 сая төгрөг, тоглоомын талбай байгуулахад 19.6 сая төгрөг, нийт 44.0 сая төгрөгийн ажлын гэрээ байгуулж, 35.2 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон боловч гэрээний хугацаа хэтэрсэн, актаар хүлээж аваагүй, хөрөнгөнд бүртгээгүй байна.

-Эрдэнэ сум нь 5.3 сая төгрөгийн өртөгтэй ногоон байгууламж, 25.0 сая төгрөгийн өртөгтэй машины зогсоол, 10.0 сая төгрөгийн өртөгтэй халуун усны тоног төхөөрөмж зэрэг нийт 40.3 сая төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлд бүртгэж, орлого аваагүй.

-Алтанбулаг сум нь 180.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, амралт, чөлөөт цаг өнгөрөөх цэцэрлэгт хүрээлэнгийн ажлыг нээлттэй тендер шалгаруулалтаар “Буянт гол” ХХК 179.4 сая төгрөгөөр 2014 оны 10 сарын 3-ны өдөр эхэлж, ажлын 38 хоногт дуусгаахаар гэрээ байгуулсан боловч ажлын гүйцэтгэл дутуу, гэрээний хугацаа хэтэрсэн, актаар хүлээж аваагүй байсан зэрэг нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 9.1 дэх заалт болон бусад дүрэм журам зөрчсөн байгаад акт, албан шаардлага өгөв.

Шинээр хэрэгжүүлж буй хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээний газар эзэмших шийдвэрийг гаргаагүйгээс шинээр хийгдсэн хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлуудын хөрөнгө оруулалт үр дүнгүй болох эрсдэл үүсч байна. Жишээлбэл: Алтанбулаг, Батсүмбэр, Жаргалант, Эрдэнэ, Архуст зэрэг сумдад хийгдсэн нийтийн эзэмшлийн зам, талбайнууд байна.

ОНХС-ийн санхүүгийн тайланг сумдууд гаргаж байгаа боловч аймгийн ОНХС-ийн дансны орлого бүрдүүлэлт, зарцуулалт, эхний үлдэгдэл өглөг, авлагыг харуулан нэгтгэсэн санхүүгийн тайлан, баланс, тайлбар тодруулга гаргахгүй, зөвхөн харилцах дансны хуулгаар гарсан орлого, зарлагын гүйлгээгээр тайлагнаж байгаа нь “Төсвийн тухай хууль”-

ийн 54 дүгээр зүйлийн 54.5, сангийн сайдын 2012 оны 43 дугаар тушаалаар батласан зааврын 10.5 дахь заалтыг тус тус зөрчсөн байна.

ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулсан уу?

Бүлэг 3

Сум, орон нутагт орон нутгийн хөгжлийн сангаар хийгдэж буй хөрөнгө оруулалтын ажилд захиалагчийн хяналт, явцын хяналт байхгүй байна.

3.1 ОНХС-ийн төлөвлөлт, зарцуулалт, хэрэгжилтийг иргэдэд ил тод мэдээлсэн үү?

Сум бүр ил тод байдлын самбар ажиллуулж, ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх ажлын төлөвлөгөө, гүйцэтгэлийг байршуулжээ.

Аймгийн хэмжээнд “Төсөв санхүүгийн ил тод байдлыг хангахад дагаж мөрдөх журам”-ын хэрэгжилтийг шалгахад 27 сум нь ил тод байдлын самбар ажиллуулж, самбарт орон нутгийн хөгжлийн сангаар хийгдэх ажлын төлөвлөгөө, өмнөх оны ажлын гүйцэтгэлийг гаргаж байршуулсан байна.

3.2 ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд тавих захиалагчийн хяналтыг хууль, журмын дагуу хэрэгжүүлсэн эсэх?

ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэж буй ажлуудад тавих хяналт байхгүй байна.

Төв аймаг нь 27 сумтай бөгөөд улс, орон нутгийн хөрөнгө оруулалт, орон нутгийн хөгжлийн сангаар хийгдэж байгаа ажлуудад хяналт тавих мэргэжилтнүүдийн тоо хангалтгүй байна. Учир нь ГХБХГ-т ажиллаж байгаа мэргэжилтнүүд нь захиалагчийн хяналтын ажлыг хийдэг бөгөөд ХО-ын ажилд хяналт тавихаас гадна зарим зураг, төсвийн ажлыг хийдэг, хөрөнгө оруулалтын ажил нь улирлын чанартай байдаг зэргээс шалтгаалан ажлын ачаалал ихтэй, хийгдэж байгаа хөрөнгө оруулалт бүрт хүрч хангалттай хяналт тавьж чаддаггүй байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр сумдад хийгдэж байгаа хөрөнгө оруулалтын ажлуудын явцад захиалагч болон мэргэжлийн байгууллагын зүгээс тавих хяналт байхгүй, ажил хүлээж авахад сумын Засаг даргын захирамжаар ажлын хэсэг томилогдож ажлыг хүлээж авдаг, гүйцэтгэгчтэй тооцсон хариуцлага байхгүй байна. Захиалагч болон мэргэжлийн байгууллагын зүгээс тавих хяналт байхгүйгээс сумдад хийгдсэн зарим ажлууд чанаргүй, гэрээний хугацаа хэтэрсэн, ажлын гүйцэтгэл дутуу зэрэг зөрчлүүд илэрлээ. Жишээлбэл:

- Зуунмод сумын төвийн хяналтын камер байршуулах 247.4 сая төгрөгийн өртөгтэй ажил нь ажлын даалгаврын дагуу хийгдээгүй байна. Жишээ нь :
 - Нийтдээ 33 цэгт 32 камер байршуулна гэж төсөвлөсөн боловч гүйцэтгэлээр 22 цэгт 27 камер байршуулсан байна. Захиалагчийн зүгээс 1 LPR камер байршуулах дутуу байгаа бөгөөд удахгүй гүйцэтгэж дуусгана гэж тайлбарлаж байна.

- Камерын сүлжээг шилэн кабелиар холбоно гэж төсөвлөсөн боловч Зуунмод сумын 2, 4 дүгээр багт байрлуулсан камерууд нь WiFi буюу утасгүй сүлжээгээр холбосон нь сүлжээний мэдээлэл дамжуулах хурд болон чанарт нөлөөлөхөөр байна.
 - Серверт мэдээлэл буюу бичлэг хадгалах хатуу диск 13-ийг байршуулна гэсэн боловч 12-ийг байршуулсан. Байршуулсан хатуу дискнээс 1 нь ажиллахгүй байсан.
 - байршуулсан 27 камераас 1 нь LPR маркын буюу шөнийн цагт автомашины дугаар таних зориулалттай хамгийн үнэтэй гэгдэж байгаа камер ажиллахгүй байсан. Үүнийг Улаанбаатар хотод ашигладаг программаар суурилуулсан учир ажиллахгүй байгаа бөгөөд удахгүй ирж засаж өгнө гэж тайлбарлаж байна.
- Бусад 26 камер нь ажлын гүйцэтгэлийн баримт бичигт тусгагдсанаар өдрийн болон шөнө ашиглах боломжтой, автомат фокус тохируулагчтай, 12Х таталттай, автомат дүрс мэдрэгч бүхий HD буюу өндөр нягтрал бүхий гэж танилцуулагдсан камерын үйл ажиллагаатай танилцахад өдрийн цагаар гаднах орчин ердийн тохиолдолд 10-15 метр орчимд байгаа тээврийн хэрэгслийн номер, явган хүний нүүр царай танигдахгүй, харагдахгүй, шөнийн цагаар тээврийн хэрэгслийн марк, өнгө, номер зэрэг, явган хүний хувцасны өнгө, нүүр царай зэрэг зүйлс нь ялгагдахгүй, харагдахгүй байна. Мөн сүлжээний хурд 10-100mb гэсэн боловч бодит байдал дээр хийсэн бичлэгүүдийг үзэхэд сүлжээний гацаа ихтэй буюу дүрс алгасалт их байгаа учир ашиглахад бэрхшээлтэй байна.
- Зуунмод суманд 24.8 сая төгрөгийн нийтийн бие засах газар, 50.0 сая төгрөгийн ногоон барилгын /контейнераар барьсан хаус/ ажил, тус сумын ЗДТГазрын иргэдэд үйлчлэх танхимын засвар шинэчлэлийг 30.0 сая төгрөгөөр хийж Зуунмод сумын 5-р багийн Иргэний танхим, мэдээллийн төвийн их засварын ажлыг гэрээний хугацаандаа бүрэн хийж гүйцэтгээгүй байхад оны эцэст дараа оны 4-р сарын 15-ны дотор хийж дуусгана гэж гүйцэтгэгч хүсэлт гаргасны дагуу үлдэгдэл мөнгө болох 3.8 сая төгрөгийг бүрэн олгоод өнөөг хүртэл дутуу ажлаа хийж гүйцэтгүүлээгүй, мөн нийтийн бие засах газрыг барьж байгуулах ажлыг 24.3 сая төгрөгөөр хийж гүйцэтгүүлэхээр төлөвлөн “Ховд тул” ХХК-тай 16.3 сая төгрөгөөр гэрээ байгуулан ажилласан боловч уг байгууламжийг хүлээж аваагүй, данс бүртгэлд авлагын болон хөрөнгийн дансанд бүртгээгүй, Номт багт Ногоон барилгын ажлаа бүрэн дуусгалгүйгээр 48.0 сая төгрөгөөр дансны авлагаар тусган ашиглалтанд хүлээж аваагүй, хойшид хэрхэн ажиллах нь тодорхойгүй зэрэг зөрчлүүд нь ОНХСангийн хөрөнгийн зарцуулалтанд хяналт тавиагүйгээс үүсчээ.
 - Сэргэлэн, Баянжаргалан, Баян сумд цэцэрлэгт хүрээлэнгийн усан оргилуур барих ажлыг чанаргүй дутуу хийсэн нь захиалагчийн хяналтыг зохих ёсоор тавиагүйгээс ашиглалт муутай хөрөнгө бэлтгэсэн, Мөнгөнморьт, Баянцагаан сумд орон нутгийн телевизийн тоног төхөөрөмжийг худалдан авч хийж гүйцэтгүүлсэн гэж тайлагнасныг газар дээр нь очиж үзэхэд уг байгууламжийг дутуу хийснээр ашиглалтанд бүрэн гүйцэд хүлээж аваагүй байгаа нь ОНХСангийн хөрөнгийн зарцуулалтанд захиалагчийн хяналтыг зохих ёсоор тавиагүйгээс уг байгууламжийг төсөвт өртгийн хэмжээнд бүрэн хийгээгүй, ашиглалтанд оруулаагүй зэрэг зөрчлүүдийг арилгуулах албан шаардлага бичлээ.



Баян сум 10,0 сая төгрөгийн Ногоон байгууламж, явган хүний зам, усан оргилуурын ажлыг дутуу чанаргүй хийсэн ашиглалтгүй байна.

Аймгаас ОНХС-ийн хэрэгжилтэд хяналт тавих захиалагчийн хяналт байхгүйгээс сумдууд ижил төрлийн ажлыг янз бүрийн өртөгөөр хийлгэж, ойролцоо өртөгтэй ажлуудын гүйцэтгэл өөр байна.



Борнуур сумын 24 сая төгрөгийн ногоон төгөл байгуулах хашаа



Баянчандмань сумын 27 сая төгрөгийн соёл амралтын хүрээлэнгийн хашаа

Мөн ОНХС-ийн хөрөнгөөр хөдөө орон нутаг, сумдад хийгдэж байгаа ажлууд нь хашаа барих, гэр худалдаж авах, явган зам барих, гэрэлтүүлэг хийх болон хог хаягдал, гэрэлтүүлгийн урсгал зардал гэх мэтчилэн ажлууд байдаг бөгөөд уг ажлуудын төсвийг мэргэжлийн байгууллага, төсөвчнөөр хийлгэдэггүй, зураг, төсвийн мөнгийг хийгдэх ажлын жагсаалтад оруулж төлөвлөдөггүй зэргээс шалтгаалан захиалагчийн хяналтын зардлыг тусгаж өгдөггүй байна. 2014 онд ОНХС-аас сумдад хийгдсэн ажлуудад захиалагчийн хяналтын зардлыг тооцож аваагүй байна.

3.3 ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг хууль, журмын дагуу хүлээж авсан эсэх?

Захиалагчийн хяналт байхгүйгээс гүйцэтгэгчтэй тооцсон хариуцлага байхгүй байна.

ОНХСангийн хөрөнгөөр хийгдсэн хөрөнгө оруулалтын ажлуудыг сумын Засаг даргын захирамжаар томилогдсон ажлын хэсэг хүлээж авдаг байна. Уг ажлын хэсэгт орсон ажилтнууд нь ажлын гүйцэтгэлийг нэг бүрчлэн тулгаж авдаггүй, баримжаагаар ажил дууссан эсэхийг шалгаад, дууссан гэж үзсэн тохиолдолд хүлээж авдаг байна. 2014 онд захиалагчийн хяналт байхгүйгээс ажил гүйцэтгэх гэрээний хугацаа хэтрүүлсэн гүйцэтгэгчтэй тооцсон, хариуцлага, алданги байхгүй байна.

3.4 Өмнөх оны акт, албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлсэн эсэх?

Өмнөх оны аудитаар өгсөн акт, албан шаардлага бүрэн хэрэгжсэн байна.

2013 онд орон нутгийн хөгжлийн санд хийсэн нийцлийн аудитаар:

1.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийж гүйцэтгэх төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх, иргэдийн саналыг авахдаа орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан, эдийн засаг нийгмийн чухал ач холбогдолтой зайлшгүй тулгамдсан асуудлыг, оновчтой эрэмбэлэн ИТХ-аараа шийдвэрлүүлэн, хэрэгжүүлж ажиллах

2.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэж буй хөрөнгө оруулалт, их засвар, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхдээ холбогдох хууль тогтоомж, заавар журмын дагуу зохион байгуулж, хэрэгжилтийг хангаж ажиллах

3.Орон нутгийн хөгжлийн сангаар хийж гүйцэтгэх төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх, саналыг авахдаа иргэдийн оролцоог хангах талаар арга хэмжээ авах

4.Аймаг, сумын хэмжээнд төлөвлөгдсөн төсөл арга, хэмжээг тайлант жилдээ хэрэгжүүлэхийн тулд гэрээний хэрэгжилтэнд тавих хяналтыг сайжруулан, гүйцэтгэгч аж ахуйн нэгж, хуулийн этгээдэд гэрээт ажлаа хийж гүйцэтгээгүй буюу дуусаагүй байхад санхүүжилтийг бүрэн олгодог зөрчлийг таслан зогсоож, он дамжсан өр авлага гаргахгүй байх

5.Аудитын шалгалтаар гарсан зөрчлийг арилган, дахин давтан гаргахгүй байхад анхаарч, ТБОНӨХБАҮХАТухай хууль зөрчсөн ГХБХГ-ын холбогдох албан тушаалтнуудад хариуцлага тооцож ажиллах гэсэн 5 зөвлөмжийн хэрэгжилтийг хүргүүлсэн.

Өмнөх онд хийгдсэн аудитаар эдгээр зөвлөмжүүдийн 1, 3, 5 дугаар заалт бүрэн хэрэгжсэн, 2 дах заалт хэрэгжээгүй, 4 дэх заалтын хэрэгжилт хангалтгүй гэж дүгнэлээ.

Өмнөх аудитаар нийт 450.0 сая төгрөгийн албан шаардлага, 29.3 сая төгрөгийн акт тавигдаж, акт, албан шаардлагын бүрэн биелсэн байна.

3.5 Шилэн дансны хуулийн хэрэгжилт 2015 оны байдлаар ямар түвшинд байна?

Сумд нь ил тод байдлын самбар ажиллуулж, ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх ажлын төлөвлөгөө, гүйцэтгэлээ байршуулсан байна.

Шилэн дансны хуулиар мэдээллийг дараахь хэлбэрээр байршуулах:

1.Шилэн дансны нэгдсэн цахим хуудас

2.Байгууллагын цахим хуудас

3.Мэдээллийн самбар гэсэн 3 хэлбэрээр хэрэгжүүлэхээр заажээ. Уг хууль нь 2015 оны 1 сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн. 2015 оны 5 сарын 1-ний өдрийн байдлаар “Шилэн дансны нэгдсэн цахим хуудас”-нд мэдээлэлээ байршуулах ажил хангалтгүй байгаа бөгөөд аймаг, сумд нь мэдээлэлийн самбарт ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх ажлын төлөвлөгөө, урд онд хийгдсэн ажлын гүйцэтгэлээ тайлагнасан байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалтын талаар ҮАГ-аас ирүүлсэн санал асуулгын маягтын дагуу 27 сум тус бүрээс дундажаар 50 хүнийг хамруулахаар төлөвлөн, санал асуулга явуулсан боловч 2 сум санал, асуулгын хуудсаа ирүүлээгүй, 25 сумаас 591 хүний санал, асуулыг хуудас нэгтгэгдлээ. Санал авсан хуудсыг нэгтгэж үзэхэд:

1.ОНХСангийн санхүүжилтийн ямар төсөл арга хэмжээг танай баг хороонд хэрэгжиж буй талаар хэрхэн мэдээлэлтэй байна вэ? гэсэн асуултын хариулсан байдлыг авч үзвэл санал асуулганд оролцогчдын 55-иас илүү хувь нь хэрэгжүүлж буй төсөл арга хэмжээг сайн мэднэ, сонссон боловч хэрэгжиж буйг мэдэгүй гэж 31 хувь нь, 13 хувь нь энэ талаар огт мэдээлэлгүй гэж хариулснаас үзэхэд энэ талын мэдээллийг иргэд хангалттай сайн мэддэгүй байгаа тул хойшид ОНХСангийн санхүүжилтээр ямар төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх буюу хэрэгжүүлж байгаа талаар иргэдийг мэдээллээр хангах ажлыг эрс сайжруулах шаардлагатай байна.

2.ОНХСангийн асуудлыг багийн иргэдийн нийтийн хуралд та оролцож байна уу? гэсэн асуултын хариулсан байдлыг авч үзвэл 35.7 хувь нь байнга, 47.2 хувь нь хааяа, 17 хувь нь огт оролцдоггүй гэж хариулсан байдлаас харахад сумын иргэдийн багийн иргэдийн нийтийн хуралд оролцох оролцоо боломжийн хэмжээнд байна.

3.Хэрвээ оролцож байсан бол зайлшгүй шаардлагатай асуудлыг иргэдээр хэлэлцүүлж чаддаг эсэх талаар таны бодол? гэсэн асуултанд оролцогчдын 29.1 хувь нь цаанаасаа бэлтгэсэн асуудлуудын жагсаалтыг хэлэлцүүлж санал авдаг, 38.6 хувь нь оролцогч иргэдээс санал авч дэвшүүлэн хэлэлцүүлдэг, 25.6 хувь дээрх хоёрын аль аль нь, 13.8 хувь нь иргэдийн саналыг бараг сонсдоггүй, нэр төдий хурал болдог гэж хариулсан байдлаас харахад 38.6 хувь буюу олонхи нь иргэдээс санал авч дэвшүүлэн хэлэлцүүлдэг гэж хариулсан байна.

4.ОНХСангийн санхүүжилтээр хэргэжүүлэхээр болсон төсөл арга хэмжээний талаар мэдээллийг зарладаг уу? гэсэн асуултанд 57.5 хувь нь тийм, 36.1 хувь нь зарладаг байх гэхдээ би сонсоогүй гэж , 6.3 хувь нь огт үгүй гэж хариулсан нь багийн удирдлагын зүгээс зарладаг боловч иргэд өөрсдөө идэвхтэй очиж оролцох тал дээр хангалтгүй байна.

5.ОНХСангаас ямар төсөл арга хэмжээ санхүүжүүлэх боломжтой тухай мэдээлэл болон таны саналыг авах хуудас танай өрхөд ирж байсан уу? гэсэн асуултанд 42,8 хувь нь саналын хуудас мэдээлэл байнга ирдэг, 41,3 хувь нь саналын ирдэггүй ч хурал болох талаар мэдээлэл ирдэг, 15,8 хувь нь саналын хуудас ирдэггүй, мэдээлэл ч өгдөггүй гэж хариулсан байна.

6.ОНХСангийн санхүүжилтээр хэрэгжүүлж буй төсөл арга хэмжээний хэрэгжилт, ашиглалтанд иргэд хяналт тавих бололцоо, механизм байгаа юу? гэсэн асуултанд 55.9 хувь нь бүрэн боломжтой, 14.4 хувь нь боломжгүй, 29.6 хувь нь энэ талаар мэдэхгүй байна гэж хариулсанаас үзэхэд ихэнх иргэд хяналт тавих бололцоотой байна гэж хариулсан байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн санхүүжилтээр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөр, арга хэмжээг төлөвлөлт, зарцуулалтын талаар төрийн байгууллага, багийн зүгээс иргэдэд мэдээллийг хүргэх, тэдний саналыг тусгах, иргэдийн оролцоо тэдгээрийн хяналт тавих боломжийн талаар дээрх санал асуулгын хариулсан дүнгээс дүгнэлт хийж үзэхэд ОНХСан бий болоод 2 жил хэрэгжиж байгаа ч энэ талын ажил ерөнхийдөө боломжийн хэмжээнд байгаа нь харагдаж байна.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараахь дүгнэлт хийж байна.

1 Төв аймгийн ОНХС-д 2014 онд ОНХНС-аас өгөх санхүүжилтийг 2727.4 сая төгрөгөөр дутуу санхүүжүүлснээс төлөвлөснөөс 58 төсөл арга хэмжээг хэрэгжээгүй байна

2. Орон нутгийн хөгжлийн сангаар хийгдэж буй хөрөнгө оруулалтын ажлуудын зураг, төсөв нь санхүүжилтийн эх үүсвэр батлагдсны дараа буюу ИТХ-ын тогтоол гарсны дараа, хийгдэж байна.

3.Сум, орон нутагт худалдан авах ажиллагааг зохион байгуулж, үнэлгээний хороонд ажиллаж байгаа ажилтнуудын мэдлэг дутмагаас ТБОНӨХБАҮХАТухай хууль зөрчигдөж байна.

4.Орон нутгийн хөгжлийн сангаар хийгдэж буй хөрөнгө оруулалтын ажилд тавих захиалагчийн хяналт хангалтгүй байгаагаас гүйцэтгэсэн ажил нь чанаргүй, гэрээний хугацаанд хийгдэхгүй, гүйцэтгэгчтэй тооцсон хариуцлага байхгүй, актаар хүлээж авч, данс бүртгэлд тусгах ажил хийгдээгүй байна.

5.ОНХС-ийн санхүүгийн тайланг сумдууд гаргадаг боловч аймгийн ОНХС-ийн санхүүгийн тайлан гардаггүй, зөвхөн харилцах дансны хуулгаар гарсан орлого, зарлагын гүйлгээгээр тайлагнаж байгаа

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн дүгнэлтэд үндэслэн аймгийн Хөгжлийн бодлогын хэлтсийн дарга Ү.Батчулуун, ГХБХБГ-ын дарга М.Хүрэлбаатар, ХААА-ны дарга Э.Амарсайхан нарт:

1.Орон нутгийн хөгжлийн сангаар хийгдэж буй хөрөнгө оруулалтын ажлуудын зураг, төсвийг хийлгэж, зураг төсөв хийлгэсний дараа хөрөнгийн эх үүсвэрийг батлуулах, иргэдийн саналын жагсаалтанд ороогүй, ИТХ-аар батлагдаагүй ажилд санхүүжилт олгохгүй байх

2. Төсвийн болон ТБОНӨХБАҮХАТухай хууль, түүнийг дагалдаж гарсан журам, дүрмийг мөрдөн ажиллах талаар холбогдох ажилтнуудын мэдлэг боловсролыг дээшлүүлэн, хуулийн хэрэгжилтэнд тавих хяналтыг сайжруулах.

3.Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулж, хууль зөрчсөн холбогдох ажилтнуудад хариуцлага тооцох

4.Орон нутгийн хөгжлийн сангаас хийгдэж буй ажилд тавих захиалагчийн хяналтыг сайжруулах ажлыг зохион байгуулж, аудитаар тавигдсан төлбөр зөрчлийг арилгах

Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга Ю.Бямбацогтод:

5.Цаашид аймгийн хэмжээний ОНХС-гийн нэгтгэсэн санхүүгийн тайланг тайлбар тодруулгын хамт хууль журмын дагуу улирал, жилээр тогтмол гаргаж хэвшүүлэхийг зөвлөж байна.

Холбогдох байгууллагын санал

Холбогдох байгууллагын санал



ТӨВ АЙМГИЙН
ГАЗРЫН ХАРИЛЦАА БАРИЛГА ХОТ
БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР

41100 Зуунмод, Төв аймаг


Утас: _____ Факс: _____

2015.05.15 № 07/1271

таний _____ нэм № _____

ТӨВ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАРТ

2014 оны "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны зарцуулалтын байдал"-д аудит хийсэн тайланг манайд 2015.05.14-ний 1/206 тоотор ирүүлсэн. Уг тайланд тусгагдсан шаардлага, зөвлөмжийг цаашид баримтлан ажиллана.

ДАРГА  М.ХҮРЭЛБААТАР



201500187

My doc toot A-5



ТӨВ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАРТ

**ТӨВ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ДЭРГЭДЭХ ХУДАЛДАН
АВАХ АЖИЛЛАГААНЫ АЛБА**

41100 Зуумод, Төв аймаг
Утас 70273539, Факс 70273579

2015.5.15 № А/039
танай 2015.5.14 -ны № 1/205

Тайлбар хүргүүлэх тухай

Орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалтын байдалд хийсэн нийцлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцан дараах тайлбарыг хүргүүлж байна.

Тайлангийн төслийн Бүлэг 2-ын 5-д Дэлгэрхаан сумын Ерөнхий боловсролын сургууль, дотуур байрны ариун цэврийн байгууламжийг хийх гүйцэтгэгчтэй гэрээ байгуулах талаар манай албаны зүгээс хүргүүлсэн зөвлөмжийг хууль зөрчсөн гэж үзжээ. Аудитын явцад энэ асуудал дээр албаны зүгээс 2015.04.14-ний өдрийн А/024 тоот мэдэгдэл хүргүүлсэн билээ.

Уг ажлын худалдан авалтыг зохион байгуулах талаар сумын засаг дарга Д.Энхбаатарт хүргүүлсэн 2014.09.23-ны өдрийн А/112 тоот зөвлөмжид хуулийн дагуу нээлттэй тендер зохион байгуулах нь зүйтэй, гэрээ шууд байгуулах нөхцөлд ТБОНӨХБАҮХАТухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.2 /оюуны өмчийн эрхийг хамгаалах шаардлагаар гэрээг зөвхөн нэг этгээдтэй байгуулах боломжтой бөгөөд түүнийг орлох этгээд байхгүй бол/ 34.1.5 /гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас нээлттэй буюу хязгаарлагдмал тендер шалгаруулалтын журмын дагуу тендер хүлээн авах доод хугацааг мөрдөх боломжгүй бол / гэсэн заалтат тусгасан нөхцөл үүссэн бол ТБОНӨХБАҮХАТухай хуулийн 34.2-дах заалтыг баримтлан /энэ хуулийн 34.1-д заасан нөхцөлийн дагуу гэрээ шууд байгуулахад захиалагч энэ хуулийн 14-16 дугаар зүйлийн шаардлагыг хангасан, тухайн бараа, ажил, үйлчилгээг гүйцэтгэх чадавхтай нэг, эсхүл түүнээс дээш тооны этгээдтэй хэлэлцээ хийж, техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл, шаардлагыг хамгийн сайн хангасан этгээдтэй энэ хуульд заасны дагуу гэрээ байгуулах бөгөөд хэлэлцээний үед хүрсэн аливаа тохиролцоог гэрээнд тусгана/ гэрээ байгуулах нь зүйтэй гэсэн зөвлөмж хүргүүлсэн.

Ямар нөхцөлд шууд гэрээ байгуулж болох талаар хуулийн заалтуудыг тодорхой дурьдаж өгсөн бөгөөд шууд гэрээ байгуулж болно гэсэн зөвлөмж хүргүүлээгүй гэж үзэж байна. Албаны зүгээс хүргүүлсэн зөвлөмжийг үндэслэн шууд гэрээ байгуулах шийдвэр гаргасан нь дээрх хуулийн заалтуудад заасан нөхцөл үүссэн гэж үзэн сумын засаг дарга гэрээ шууд байгуулах аргыг хэрэглэсэн бол гэрээ шууд байгуулах нөхцөл үүссэн үндэслэлийг сумын ЗДТГ болон сумын Засаг даргаас тодруулах нь зүйтэй гэж үзэж байна.

Иймд та бүхнийг Аудитын явцын дунд хүргүүлсэн 2015.04.14-ний өдрийн А/024 тоот мэдэгдэл, сумын Засаг дарга Д.Энхбаатарт хүргүүлсэн 2014.09.23-ны өдрийн А/112 тоот зөвлөмж зэргийг дахин хянаж үзэн аудитын дүгнэлтийг гаргахыг хүсье.

Хавсралт 2 хуудастай.

ДАРГА  Э.АМАРСАЙХАН



01100031



ТӨВ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАРТ

ТӨВ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ДЭРГЭДЭХ ХУДАЛДАН
АВАХ АЖИЛЛАГААНЫ АЛБА

41100 Зуулмод, Төв-аймгаг
Утас: 70273539, Факс: 70273579

2015 4 14 № А/024

танай _____ -ны № _____ -т

Мэдэгдэл хүргүүлэх тухай

Дэлгэрхаан сумын Засаг дарга Ч.Энхбаатар нь сумандаа улсын төсвийн хөрөнгөөр хийгдэх энэхүү ажлын талаар удаа дараа уулзаж зөвлөгөө авч байсан бөгөөд анх Ану сервис ХХКомпаниар төсөв хийлгэж, ажлын зураг хийлгэсэн байсан. Хамгийн сүүлд ирж уулзахдаа Ану сервис ХХК нь энэхүү ажлыг хийхгүй гэж мэдэгдсэн. Одоогоор ганцхан ATMOR ХХКомпанитай шууд гэрээ байгуулах хүсэлтэй байна гэж манай байгууллагад хандсан.

Иймд манай байгууллага шууд гэрээ байгуулахад хуулийн 34-р зүйлийг мөрдлөгө болгон анхаарах шаардлагатай гэж тайлбарласаны дагуу 2014.09.23-ны А/112 тоот албан зөвлөмжийг гаргаж өгсөн байгаа.

Энэхүү албан зөвлөмж нь Ч.Энхбаатар засаг даргыг ATMOR компанитай шууд гэрээлэн ажиллахыг зөвлөсөн шийдвэр биш юм.

Тиймээс Дэлгэрхаан суманд хийгдсэн шууд гэрээлэх энэхүү ажилд манай зөвлөмж эцсийн шийдвэр болохгүй.

ДАРГА  Э.АМАРСАЙХАН



01100016


ТӨВ АНГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ДЭРГЭДЭХ ХУДАЛДАН
АВАХ АЖИЛЛАГААНЫ АЛБА
4100 Улаанбаатар, Төв 4100
Утас: 70273533 Факс: 70273576

2014.09.23 № 7/112
танил 2014.07.07 № 6/1436

ДЭЛГЭРХААН СУМЫН ЗАСАГ ДАРГА
Ч.ЭНХБААТАР ТАНАА

Танай ирүүлсэн албан бичигтэй танилцлаа.
Танай батлагдсан төсвөөр хуулийн дагуу нээлттэй
тендер зарлаж зохион байгуулах нь зүйтэй байна.

Гэвч цаг хугацааны хувьд бага байгаа бол
АТМОР ХХК-тай гэрээ шууд байгуулахад
ТБОНӨХБАҮХАТ хуулийн 34 дүгээр зүйл 34.1.2, 34.1.5
заалтууд тохирч байгаа бол 34.2 дах заалтыг
баримтлан гэрээ байгуулах нь зүйтэй юм.

ДАРГА  Э.АМАРСАЙХАН
ТТС5547 ± 3864502

37